

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,ЗАСАГ ДАРГЫН  
ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТАЛААР:

Монгол Улсад хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага байгуулагдсаны 60 жил, олон улсын хөдөлмөрийн байгууллага байгуулагдсаны 100 жилийн ойд зориулсан нээлттэй хаалганы өдөрлөг Говь-Алтай аймгийн Жанчивын талбайд 2019 оны 4-р сарын 30-ны өдөр болж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга нээж үг хэллээ.

Цагаатгалын нөхөн олговор авах мэдээллийн санд нийт 5 хүн бүртгэгдсэн байна.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл, Цагдаагийн газар, Улаан загалмайн хороо, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хамтран “Өсвөрийн сэргийлэгч -2019” тэмцээнийг 04-р сарын 24-ний өдөр зохион байгууллаа.

Говь - Алтай аймгийн харьяат Эхийн алдар 1-р одонгоор шагнуулах 8, Эхийн алдар 2-р одонгоор шагнуулах 138 эхчүүд нийт 146 эхийн материалын бүрдүүлэлт хийж, архивын 3 нэгж материалыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүллээ.

Монгол Улсын Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисст аймгийн салбар комиссоос 2019 оны 1-р улиралд хийсэн ажлын ажлын тайлан, аймгийн хэмжээнд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдэд зориулан босгосон хөшөө, самбар, багана, суваргын судалгааг хүргүүллээ.

ЗГХЭГ-аас зохион байгуулдаг ээлжит цахим хурал 04 дүгээр сарын 23-ны өдөр болж, хуралд ХНХ-ын сайд С.Чинзориг, ЗГХЭГ-ын дэд дарга У.Бямбасүрэн, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч С.Баатаржав болон холбогдох яам, агентлагийн төлөөлөл, 21 аймаг, нийслэлийн удирдлагуудтай оролцлоо.

Хурлаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэхэд Засгийн газар анхаарал хандуулж байгаа, тэднийг асарч халамжилж байгаа ар гэрийнх нь хүмүүсийг ажилтай болгоход орон нутгийн удирдлагууд анхаарах, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эхийн аль нэг нь заавал хажууд нь байх шаардлагатай учраас орон нутгийн боломжид тулгуурлаж дэмжих, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг тусгаарлах бус харин ч нийгэм, хамт олон дунд нь байлгахыг дэлхий нийтээр чухалчилж байгаа учраас энэ жишгийг дагах, харин тусгай анги, танхим нээж, ялгаварлан гадуурхахгүй байхад анхаарал хандуулахыг орон нутгийн удирдлагуудад үүрэг, чиглэл болголоо.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд аймагт баригдаж ашиглалтад орж буй 40 авто машины зогсоолтой, 2 блок, 60 айлтай, 120 айлын орон сууцны барилга байгууламжийн нээлтийн үйл ажиллагаа 04 дүгээр сарын 29-нд зохион байгуулагдлаа.

Үйл ажиллагааг УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд нээж үг хэлсэн бол Барилга,хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Барилга,хот байгуулалтын яамны Инженерийн дэд

бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Т.Болорчулуун аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал, аймгийн Засаг дарга С.Гансэлэм, аймгийн Засаг даргын орлогч Ж.Ганбат, Ерөнхий гүйцэтгэгч "Хөх бүрдний эх" ХХК-ийн захирал Н.Энхтайван нар оролцож үг хэллээ.

Тус орон сууцны барилгын ерөнхий захиалагчаар Барилга, хот байгуулалтын яам, Санхүүжүүлэгч байгууллагаар Монгол Улсын Хөгжлийн банк, Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаар "Төрийн орон сууцны корпорац" ТӨХХК, Ерөнхий гүйцэтгэгчээр "Хөх бүрдний эх" ХХК, Зураг төсөл зохиогчоор "Гандирс-Орд" ХХК, болон Аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан юм.

Есөнбулаг сумын зарим сургуулийн гуравдугаар ээлжийг арилгаж, ачааллыг бууруулах замаар сургалтын чанарыг ахиулах, хүүхэд хөгжүүлэх орчин бүрдүүлэх зорилго бүхий гадаад хэлний гүнзгийрүүлсэн сургалттай Ерөнхий боловсролын IV сургууль нээлтээ хийлээ.

Нээлтийн үйл ажиллагааг аймгийн Засаг дарга С.Гансэлэм нээж, тус арга хэмжээнд УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хороон дарга Ш.Раднаасэд, БХБЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, аймгийн БСУГ-ын удирдлага хамт олон, хэлтэс, агентлагийн дарга нар, эцэг эх, сурагчдын төлөөлөл өргөнөөр оролцлоо.

Япон улс руу үндсэн болон гэрээт нөхцөлөөр ажиллах хүч гаргах чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах үйл ажиллагаа 2019 оны 4 дүгээр сарын 29-ий өдөр аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд зохион байгуулагдлаа.

Япон хэлний сургагч багш нарыг сонгон шалгаруулж сургалтын төв байгуулан шалгалтын босго оноо хангасан хүмүүсийг тоо харгалзахгүй Япон улсад ажиллах нөхцөлийг бүрдүүлэх ач холбогдолтой юм

Уулзалтад УИХ-ын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд, Аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал, аймгийн Засаг дарга С.Гансэлэм, аймгийн Засаг даргын орлогч Ж.Ганбат, нөгөө талаас "Фүкүтоми Би Жи Ай интернейшнл" ХХК-ий захирал Ж.Эрдэнэбулган, "Фүкүтоми Би Жи Ай интернейшнл" ХХК-ий Япон хэлний багш Э.Цэрэнбал нар оролцлоо.

Хамтран ажиллах санамж бичигт аймгийн Засаг дарга С.Гансэлэм, "Фүкүтоми Би Жи Ай интернейшнл" ХХК-ий захирал Ж.Эрдэнэбулган нар гарын үсэг зурав.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас Улсын төрөлжсөн олимпиадын 2-ын давааг 14 судлагдахууны 62 төрлөөр зохион байгуулж тус олимпиадад 988 сурагч, 644 багш оролцлоо. Техник технологийн 3-ын давааны олимпиадад оролцсон багш нараас Есөнбулаг сумын ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн багш Ж. Энхбаатар Улсад түрүүлж, ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн сурагч Б. Хишигбаяр 3 дугаар байр, Хантайшир-Эрдэм цогцолбор сургуулийн сурагч Б. Анударь 5 дугаар байр, биологийн Улсын олимпиадад 3 дугаар сургуулийн багш Д.Тунгалаг тусгай байр эзэлсэн амжилттай оролцлоо. Улсын төрөлжсөн олимпиадын шагналыг УИХ-ын гишүүн бөгөөд Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд ивээн тэтгэж сурагчийн 30 төрөл, багшийн 14 төрлийн олимпиадын эхний 3 байранд шалгарсан 90 сурагч, 43 багшийг нийт 7 сая төгрөгөөр ивээн тэтгэсэн юм.

2019 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр Эрүүл мэндийн газрын төрийн жинхэнэ албан хаагчдад "Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулахад анхаарах асуудал", 04 дүгээр сарын 05-ны өдөр Мэргэжлийн хяналтын газрын албан хаагчдад "Бодлогын

баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг хэрэгжүүлэх талаар" сургалт зохион байгуулж, нийт 44 албан хаагч хамрагдлаа.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг Есөнбулаг сумын 1, 3, 4 дүгээр сургуулийн хүчин чадал, хамран сургах тойрог, бүтэц, зохион байгуулалт, орон тоо нь стандартад нийцэж буй эсэх талаар үнэлэлт, дүгнэлт өгч ажиллалаа.

УИХ-ын гишүүн бөгөөд Хууль зүйн байнгын хорооны Ш.Раднаасэд, 04 дүгээр сарын 29-нд аймагт ажиллах үеэр багш сурагчдад амжилт хүсч, шагналыг гардуулав. Шагнал гардуулах арга хэмжээ аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд болж аймгийн Засаг дарга С.Гансэлэм, Засаг даргын орлогч Ж.Ганбат нар оролцлоо. “Жендэр ба хүний эрх” сургалтыг төрийн байгууллагын удирдлагуудад 2019 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа.

Төрийн байгууллагуудад хүний эрхийн хяналт шалтгалтыг 2019 оны 04 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд Хүний эрхийн комиссын ажлын хэсэгтэй хамтран хийлээ.

“Цэвэр орчин-Эрүүл Алтай” аяныг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулж, хуралдлаа. Тус аянг 2019 оны 04 дүгээр сарын 19-нөөс 11 дүгээр сарын 19-ний өдөр хүртэл зохион байгуулахаар болж нээлтийг 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр аймгийн төв талбайд хийлээ.

“Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хэсгийг байгуулж, хуралдлаа. Хөтөлбөрийн нээлт 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр орон даяар нэгэн зэрэг эхлэлээ.

НҮБ-ын Хүүхдийн сангийн олон улсын зөвлөх Sharlene Ramkissoon, Нийгмийн бодлогын хөтөлбөрийн ахлагч Н.Энхнасан, ХЭОН-ийн зөвлөх Б.Зояа нар 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд манай аймагт ажиллаж хөдөөгийн малчин өрхийн нийгмийн халамж, хүүхдийн нийгмийн хамгааллын тулгамдаж буй асуудалд судалгаа хийлээ. Судалгааны хүрээнд Алтай, Бугат, сумдын сургууль, цэцэрлэгийн насны хүүхэдтэй малчин өрхийн амьдрал нийгмийн халамж үйлчилгээний хүртээмжийг судлалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эмзэг бүлэгт амьдарч байгаа айлын аж байдалтай очиж танилцлаа.

Шинэ төрх эмнэлэгийн нээлтийг 2019 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр хийлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын газраас зохион байгуулж байгаа “Спорт ба хөгжил” сэдэвт баруун бүсийн сургалтыг аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд 2019 оны 04 дүгээр сарын 25-26 өдрүүдэд зохион байгуулж байна.

Нээлтэд ЗГХА-БТСГ-ын дарга, МУГТ Ц.Шаравжамц, БСШУСЯ-ны ахлах мэргэжилтэн О.Гэрэл, аймгийн ИТХ-ын дарга Л.Батжаргал, НБХ-ийн дарга М.Эрдэнэбилэг, БТСГ-ын дарга Н.Бямбацогт нар оролцлоо. Баруун бүсийн сургалтад Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгийн биеийн тамир спортын салбарын 81 албан хаагч хамрагдлаа.

Аймгийн Засаг даргын дэргэдэх зөвлөл тайлант сард нэг удаа хуралдаж “Татвар төлөгчдийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх тухай хэлэлцэж, аймгийн хэмжээнд татвар төлөлтөөрөө тэргүүлсэн “TOP-10” аж ахуйн нэгжийг шалгарууллаа.

“TOP-10” аж ахуйн нэгжээр:

- “Ентүм” ХХК

- “Арвин бэлт” ХХК
- “Барилга байгууламж” ХХК
- “Ундррам-Оюу” ХХК
- “Майхан гол” ХХК
- “Шатат” ХХК
- “Харшийн цуурай” ХХК
- “Буудайн хөх уулс” ХХК
- “Айргийн хад” ХХК
- “Буян ундрал” хоршоо тус, тус шалгарсан байна.

Монгол Улсын Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Сангийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд нарын хамтран баталсан удирдамжийн дагуу 4 дүгээр сарын 25-ны өдрөөс 5 дугаар сарын 25-ны өдрүүдэд улсын хэмжээнд “Сум хөгжүүлэх сангийн улсын үзлэг”- ийг зохион байгуулж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд тус үзлэгийг зохион байгуулах 3 ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, сумдад ажиллах үйл ажиллагааны чиглэлийг батлаад байна.

“ World learning “ төрийн бус байгууллага нь АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн /USAID/ санхүүжилтээр 25-40 насны залуу манлайлагчдыг чадавхжуулах нийгэмд эерэг өөрчлөлт авчрахад нь дэмжих зорилготой “Lead Mongolia” хөтөлбөрийг дөрөв дэх жилдээ хэрэгжүүлж байна. Уг хөтөлбөрийн танилцуулгыг 04 дүгээр сарын 17-ны өдөр Аймгийн Засаг даргын Тамгын газарт зохион байгуулан, хөтөлбөрийн талаар 40 гаруй залуучууд оролцож мэдээлэл авлаа.

Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 23 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийг улирал бүр хүлээн авч, биелэлтийг тооцох бөгөөд энэхүү төлөвлөгөөний холбогдох арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлсэн, хугацаандаа тайлагнасан байдал нь сумдын Засаг дарга, хэлтэс, агентлагийн дарга нарын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг дүгнэх нэг үзүүлэлт болгохоор шийдвэрлэсэн тухай сум, агентлагуудад албан бичгээр чиглэл хүргүүллээ.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн онлайн нэгдсэн программ-е-оффисын систем нэвтрүүлэх ажлыг аймгийн хэмжээнд ашиглах олсонтой холбогдуулан бүх сум, төрийн байгууллагын ажилтнуудад сургалт зохион байгууллаа. Тус системийг нэвтрүүлснээр цаасан суурьтай бичиг баримт багасч, төрийн байгууллагуудын мэдээлэл, солилцох байдал түргэн шуурхай болж, түүнд тавих удирдлагын хяналт сайжрах ач холбогдолтой юм.

Төрийн үйлчилгээний нэгдсэн төвөөр 04 дүгээр сард давхардсан тоогоор 1400-1600 иргэд хөдөлмөрчид төрийн үйлчилгээг авсан байна.

Иргэдээ сонсох нээлттэй утас 7048-1111-д холбогдон мэдээлсэн иргэний санал, гомдол, хүсэлтийг холбогдох байгууллагуудад [www.7048-1111.mn](http://www.7048-1111.mn) программаар шилжүүлэн шийдвэрлүүлэн ажиллалаа. Тайлант сард нийт 17 өргөдөл гомдол ирсэн байна.

## ХОЁР. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД:

Аймгийн Засаг дарга 4 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 178 захирамж гаргасан байна. Захирамжийн ил тод байдлыг хангах ажлын хүрээнд аймгийн цахим сайтад байршуулан ажиллаж байна.

Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн П.Оюунчимэгээр ахлуулсан ажлын хэсэг 2019 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд Говь-алтай аймагт ажиллалаа. Тус ажлын хүрээнд “Жендэр ба хүний эрх” сэдэвт төрийн байгууллагуудын удирдах албан тушаалтнуудад зориулсан сургалтад аймгийн ИТХ-н дарга, аймгийн Засаг дарга, Засаг даргын орлогч, аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, болон Засаг даргын дэргэдэх 22 агентлагийн дарга нар хамрагдлаа.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь Засаг даргын дэргэдэх агентлагуудаас сонгон хяналт шалгалтын ажлыг зохион байгууллаа.

Монголын хуульчдын холбооноос ирүүлсэн “Хуулчийн Про-боно-2019” өдрийг орон нутагт зохион байгуулахаар холбогдох хуулийн байгууллагатай хамтран ажиллаж 5 сарын 02-03-ны өдрүүдэд зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Тайшир сумын Засаг даргаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргаар ахлуулсан ажлын хэсэг оролцон төрийн албаны тухай хуулиар сургалт зохион байгууллаа.

Аймгийн Цагдаагийн газар нь цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд хэрэгжүүлэн ажиллалаа.

Тус газраас Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2019 онд дэвшүүлсэн зорилт, 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх салбар төлөвлөгөөг боловсруулан, биелэлт үр дүнг тооцон ажиллалаа. Үүнд:

Нэг. Эрүү хэв журмын нөхцөл байдлын танилцуулга:

2019 оны эхний 04 дүгээр сард аймгийн хэмжээнд төрийн болон аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгөнд 238,6 сая төгрөгийн хохирол учирсан 100 гэмт хэрэг үйлдэгдсэнийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 30хэргээр буюу 42,9%-аар, учирсан хохирол 181,3 сая төгрөгөөр буюу 4,2 дахин тус тус өссөн байна.

**Эрүүгийн хуулийн тусгай ангийн бүлэглэлээр нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан үзвэл:** хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 5 хэргээр буюу 23,8%-иар, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 1 хэргээр буюу 1 дахин, хулгайлах гэмт хэрэг 3 хэргээр буюу 14,3%, мал хулгайлах гэмт хэрэг 9 хэргээр буюу 3,3 дахин, залилах гэмт хэрэг 6 хэргээр буюу 2 дахин, дээрэмдэх гэмт хэрэг 1 хэргээр буюу 1 дахин, хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 4 хэргээр буюу 3 дахин тус тус өсч, хүнийг алах гэмт хэрэг 1 хэргээр буюу 1 дахин, хүнийг амиа хорлох нөхцөл байдалд хүргэх гэмт хэрэг 1 хэргээр буюу 50%-аар, хүчиндэх гэмт хэрэг 1 хэргээр буюу 1 дахин, хөрөнгө завших гэмт хэрэг 1 хэргээр буюу 25%-аар тус тус буурсан байна.

Нийт хэргийн 26%-ийг хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, 24%-ийг хулгайлах, 13%-ийг мал хулгайлах, 12%-ийг залилах, 6%-ийг хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг гэмт хэргүүд эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирлын 56%-ийг хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд нөхөн төлүүлсэн байна. Гэмт хэргийн илрүүлэлт 40,2%-тай байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 10,4 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Нийт үйлдэгдсэн гэмт хэргийн 48 хэрэгбуюу 48% нь аймгийн төв буюу Есөнбулаг сумд, 9 хэрэг буюу 9% нь Жаргалан сумд, 6 хэрэг буюу 6% нь Тайшир, Цогт сумдад, 5 хэрэг буюу 5% нь Хөхморьт сумд, 4 хэрэг буюу 4% нь Цээл, Шарга сумдад, 3 хэрэг буюу 3,% нь Баян-Уул, Дэлгэр сумдад, 2 хэрэг буюу 2% нь Алтай, Бугат, Тонхил, Төгрөг, Чандмана сумдад, 1 хэрэг буюу 1% нь Дарив, Халиун сумдад тус тус үйлдэгдсэн ба Бигэр, Эрдэнэ сумдад гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Оны эхний 04 дүгээр сард иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, эрх зүйн зөрчлийн шинжтэй 516 гомдол, өргөдөл мэдээлэл хүлээн авч шалгаснаасгэмтхэргийншинжтэй 212 өргөдөлгомдлын191 буюу 90%-ийг 5 хоногт шийдвэрлэсэн ба нийгмийн хэв журам зөрчсөн 5364 зөрчил илрүүлэн шалгаж, 157 хүн эрүүлжүүлж, 5198 иргэнд 170,6 сая төгрөгийн торгуулийн шийтгэл оногдуулсан байна.

Гэмт хэрэг зөрчлийн гаралтыг бууруулах ажлын хүрээнд цагдаагийн төв байгууллагаас зохион явуулсан “Байгалиа хамгаалъя”, “Автомашин-2019”, “Залилан” нэгдсэн арга хэмжээнүүдийг болон орон нутгийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд уялдуулан “Шаг согтуу”, “Мотоцикл”, “Хулгайчаас сэрэмжилье” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллалаа.

Цагдаагийн газраас санаачлан тайлангийн хугацаанд дараах ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа.

1. Гэмт хэргийн илрүүлэлтийг ахиулах чиглэлээр удирдлага зохион байгуулалтын арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлсний үр дүнд тайлангийн хугацаанд тус аймгийн Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт үйлдэгдэн хүний амь нас хохирсон 2 хэргийг Эрүүгийн цагдаагийн тасгийн алба хаагчид мэргэжлийн өндөр ур чадвар гарган, богино хугацаанд илрүүлэн ажиллалаа.

2. Хэсгийн төлөөлөгч нарын 2019 оны 01 дүгээр улирлын нэгдсэн цугларалт сургалтыг 04 дүгээр сарын 23-25-ны хооронд зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд сумдын цагдаагийн алба хаагч нарыг 2019 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Нутгийн удирдлагын ордонд болсон хууль сахиулах байгууллагуудын хамтарсан зөвлөгөөнд хамруулан, шинээр батлагдсан хууль тогтоомж, журам зааврыг сурталчлах чиглэлээр сургалтуудыг зохион байгуулж, алба хаагчдын албаны бэлэн байдлыг шалгаж ажиллалаа.

3. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас зохион явуулж буй “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2019” арга хэмжээний хүрээнд “ Эрүүл, аюулгүй ирээдүйн төлөө” их цэвэрлэгээний аяныг 04 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулж, байгууллагын гадна, дотор орчны цэвэрлэгээг хийж гүйцэтгэлээ.

4. Алба хаагчдын мэргэжлийн мэдлэг ур чадварыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд “Хамгаалах хувцас хэрэглэл, тусгай хэрэгсэл хэрэглэх ур чадварын тэмцээн”-ийг 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулан, идэвхи санаачлагаатай оролцсон тасаг, алба хаагчийг шалгаруулан, шагнаж урамшууллаа.

5. “Эрүүл цагдаа” хөтөлбөрийн хүрээнд аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран төвийн 84 алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд хамруулан, Нийгмийн эрүүл мэндийн төвтэй хамтран “Зөв хооллолт” сэдэвт 1 цагийн сургалтыг зохион явууллаа.

6.Байгууллагын өнгө үзэмжийг сайжруулах, алба хаагчдын ажиллах орчин нөхцлийг сайжруулах ажлын хүрээнд иргэдийн хүлээлгийн танхим, хурандаа генерал Ж.Авхиагийн нэрэмжит “Алдрын танхим”-д засвар үйлчилгээ хийлээ.

7.Халиун сум дахь цагдаагийн кабоны их засварын гүйцэтгэгчийг шалгаруулах ажлын хэсгийн хурлыг Орон нутгийн өмчийн албатай хамтран зохион байгуулж,

гүйцэтгэгчээр Айргийн хад” ХХК-ыг шалгаруулан, хамтран ажиллах гэрээ байгууллаа.

8. Архивын улсын үзлэгийг угтаж, байгууллагын “Баримт бичгийг нягтлан шалгах комисс”-ын хурлыг зохион байгуулж, байгууллагын 2019 оны хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг баталгаажуулан, 1984-2017 оны түр, байнгын болон 70 жил хадгалах баримт бичгүүдийн бүртгэлийг гаргаж, хянуулахаар албан бичгээр Төв архивын газарт хүргүүлсэн.

9. Хүний нөөцийн нөхөн хангалтыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Мөрдөн байцаах тасгийн мөрдөгчийн сул орон тоонд Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрээр цагдаагийн дэслэгч О.Хишиг-Эрдэнийг мөрдөгчөөр томилуулсан.

### ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮ, ХУДАЛДАН АВАХ ҮЙЛҮ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР

Эхний 03 сарын байдлаар орон нутгийн төсвөөс сумдад 4415,2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, сумдын эрүүл мэндийн төвүүдэд 2280,4 сая төгрөг, боловсролын салбарын хувьд 9044,8 сая төгрөгийн санхүүжилтийг хуваарийн дагуу бүрэн олгоод байна.

Улсын төсвөөс орон нутагт 4155,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг, 9652,1 сая төгрөгийн тусгай зориулалтын шилжүүлэг, 971,3 сая төгрөгийн орон нутгийн хөгжлийн сангийн шилжүүлгийг тус тус олголоо.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн 1 дүгээр багц амжилтгүй болж, 2 дугаар багцад "Барилга байгууламж" ХХК шалгарч, 3 дугаар багцыг Барилга хот байгуулалтын яаманд түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгөөр тендер зарлах боллоо.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Хөхморьт сумын Ёслол хүндэтгэлийн өргөө барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Их морьт Эрдэнэ" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх өвс тэжээлийн агуулах барих /Тайшир сумын Далан баг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Орд харш" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний зардаар санхүүжилт нь хийгдэх Есөнбулаг сумын 4-р сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Ноёлогч табозн" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Хөрөнгө балансаас балансад шилжүүлэхийг зөвшөөрөх тухай, хөрөнгө акталж, үнэ тогтоон худалдан борлуулах тухай, худалдах хөрөнгийн жагсаалт баталж, доод үнэ тогтоох тухай, хөрөнгө акталж данснаас хасахыг зөвшөөрөх тухай, дахин дуудлагын худалдаа явуулах тухай асуудлуудыг аймгийн Засаг даргын Зөвлөлийн

хурлаар хэлэлцүүлж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд өргөн мэдүүлээд байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх Цээл сумын Эрүүл мэндийн төвийн гадна тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Харшийн цуурай" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Алтай суманд 50 ковш худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт "Уран минж хийц" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Бугат суманд 30 ковш худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт "Термо элект трейд" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай хотын нийтийн тээврийн 2 автобус засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт гүйцэтгэгч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Алтай хотод хатуу хучилттай авто зам барих /авто зам явган зам дугуйн зам/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Үлийн цагаан огтоно, царцаа устгах /Есөнбулаг Рашаант баг/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Буудай хиймор" хоршоо шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Санхүүгийн хяналт аудитын албанд автомашин худалдан авах барааны нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерт нэг ч оролцогч материал ирүүлээгүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Халиун сумын цагдаагийн байрны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Айргийн хад" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах /Тайшир, Цогт, Эрдэнэ, Есөнбулаг Наран багт/ ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт "Сойл инжинеринг" ХХК шалгарсан тул захиалагчид гэрээ байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжилт нь хийгдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газарт суудлын автомашин нийлүүлэх



барааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт гүйцэтгэгч шалгараагүй тул захиалагчид гэрээ шууд байгуулан ажиллах үнэлгээний хорооны зөвлөмжийг хүргүүллээ.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Есөнбулаг сумын 5 багт 7 хүүхдийн тоглоомын талбайг засварлах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн нээлт боллоо. Тендер үнэлгээний шатандаа байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Есөнбулаг сумын төв 17 ширхэг цамхагт гэрэл байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Аймгийн байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгал, уламжлалт зан заншлын талаар богино хэмжээний баримтат кино хийх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт нь хийгдэх Жаргалан толгойгоос Баарангийн давааны авто зам дагуух ногоон байгууламжийн усалгааны зориулалтаар худаг гаргах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлалаа.

Төрийн болон орон нутгийн өмчит 194 байгууллагын хөрөнгийн дахин үнэлгээний тайланг хянан хүлээн авлаа.

### ДӨРӨВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН ЧИГЛЭЛЭЭР

Азийн хөгжлийн банкны Хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжлийн төслийн нэмэлт санхүүжилтээр “Нэмүү өртгийн сүлжээг хөгжүүлэх төслийн зээл санал” сэдэвт сургалт хэлэлцүүлэгт аймгийн мал аж ахуй газар тариалан оёдолын үйлдвэрлэлийн чилэлийн үйл ажиллагаа явуулж байгаа хоршоо, ХХК-ий төлөөлөл 40 хүнийг оролцууллаа.

ХХААХҮ-ийн сайдын 2018 оны А/173 тоот тушаалаар 2017 онд арьс шир бэлтгэн тушаасан 18 сумын 3896 малчин, мал бүхий иргэдэд 532.5 сая төгрөгийн урамшуулал олгогдох болсон. Одоогоор 2444 малчин өрхийн харилцах дансанд 311.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдсэн байна. 2017 оны арьс ширний урамшууллын үлдэгдэл санхүүжилт Мал хамгаалах сангаас 04 дүгээр сарын 17-ны өдөр Монгол банкруу шилжигдсэн байна. Энэ сардаа багтаад малчдын дансанд гүйлгээ хийгдэнэ.

Аймгийн хэмжээнд 2018 оны жилийн эцсээр 1570.1 мянган хээлтэгч мал тоологдсон. Нийт хээлтэгчийн 82 хувь буюу 1287.6 мянган толгой мал төллөхөөс 886.7 мянган толгой эх мал төллөж, мал төллөлт 68.8 хувь, 865.4 мянган төл бойжиж, төл бойжилт 97.6 хувьтай байна.

Нийт гарсан төлийн 2.4 хувь буюу 21.5 мянган толгой төл мал хорогдсон. Зүй бусаар 31.1 мянган толгой том мал хорогдсон байна. Мөн 64.2 мянган толгой эх мал хээл хаясан мэдээтэй байна.

Том малын зүй бус хорогдол, мал төллөлт, төл бойжилт, хаваржилтанд тулгарч буй бэрхшээл, цаг үеийн талаарх мэдээллийг долоо хоног бүрийн Пүрэв гариг бүр сумдаас авч нэгтгэн Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яам, Онцгой байдлын газарт тус тус хүргүүлэн ажиллаж байна.

Төгрөг сумд зохион байгуулагдсан “Орон нутгийн хөгжилд бидний оролцоо” сэдэвт малчдын зөвлөгөөнд Мал эмнэлгийн газрын дарга, ХХААГ-ын мал аж ахуйн албаны дарга зэрэг хүмүүс оролцож Мал амьтаны эрүүл мэндийн тухай, Малын генетик нөөцийн тухай хууль болон Мал аж ахуйн өнөөгийн байдал цаашдын зорилт үйл ажиллагааны талаар мэдээлэл хийсэн. Зөвлөгөөнд Төгрөг сумын 5 багийн нийт 120 малчин оролцлоо.

Аймгийн “Бэлчээр хариуцлагажуулах журам”-ын төслийг танилцуулах уулзалтыг 4 сарын 28-нд Баян –Уул сумын Баянбогд багт хийж, нийт 40 гаруй иргэд оролцлоо.

Аймгийн услалтын системүүдийн болон нийт тариалангийн талбайн судалгааг гарган, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэв.

Судалгаагаар нийт 5590 га талбайг газар тариалангийн чиглэлээр ашиглах боломжтой судалгаа гарсан. Нэг бүр нь 120 м.кв талбай бүхий 2 хүлэмжийг Есөнбулаг сумын 2 иргэнд олголоо.

Газар тариалан эрхлэгчдийн улсын зөвлөгөөнд аймгийн ИТХ-ын дарга, ХХААГ-ын мэргэжилтэн, тариаланч ногоочид зэрэг 8 хүнийг оролцууллаа.

Хоршоо, газар тариалан эрхлэгчдийн аймгийн зөвлөгөөнийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар хамтран 04 дүгээр сарын 29-ны өдөр зохион байгууллаа.

Зөвлөгөөнд Улсын их хурлын гишүүн, Хууль зүйн байнгын хорооны дарга Ш.Раднаасэд, ИТХ-ын дарга Л.Батжаргал, аймгийн Засаг дарга С.Гансэлэм, аймгийн Засаг даргын орлогч Ж.Ганбат, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын мэргэжилтэн Д.Есөн-Эрдэнэ, “Алтай нутгийн хөгжлийн төлөө” ТББ-ын тэргүүн Д.Ариунболд, Монгол Улсын гавьяат эдийн засагч Б.Авирмэд нар болон сумдын Засаг дарга нар, хөдөө аж ахуйн мэргэжилтнүүд, хоршоо, газар тариалан эрхлэгч 200 гаруй хүн хамрагдаж, тус зөвлөгөөнөөс уриалга гаргалаа.

Гамшгийн үеийн 100.0 мянган хүний 100 хоногийн хүнсний хэрэгцээний судалгааг гаргаж Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Хүнсний үйлдвэрийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газарт хүргүүлээ. Мөн Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны хүнсний үйлдвэрийн бодлого хэрэгжилтийг зохицуулах газарт тус аймгаас Улаанбаатар хотруу 2019 оны 4 дүгээр сарын 22-25-ны хооронд тээвэрлэсэн махны судалгааг гаргаж хүргүүлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай болон Үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулиудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг дэмжих дотоодын худалдан авалтыг

нэмэгдүүлэх, орон нутгийн брэнд бүтээгдэхүүнийг таниулан сурталчлах зорилгоор “Алтайд үйлдвэрлэв” каталогийг хэвлэхээр төлөвлөн сумдаас бүтээгдэхүүний судалгааг авч нэгтгэж байна.

## ТАВ. БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТ, ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд найрамдах Австри Улсын Засгийн газар хооронд байгуулсан санхүүгийн хамтын ажиллагааны хэлэлцээрийн хүрээнд тус аймагт хэрэгжих “Тайшир-Алтайн усан хангамжийн төсөл”-ийг Австри улсын 14.0 сая еврогийн хөрөнгөөр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн бөгөөд Барилга, хот байгуулалтын яам хариуцаж Бүгд найрамдах Австри Улсын " Тиролер Рохре" ХХК-тай " Зураг төсөл-нийлүүлэлт-барилга угсралт"-ын ажлын гэрээ байгуулан барилгын ажил эхлэхэд бэлэн боллоо.

Алтай хотыг ундны цэвэр усаар хангаж байгаа өнөөгийн төвшинг бататган цаашид төгс шийдвэрлэх зорилгоор Завхан голоос аймгийн төв хүртэлх 50 гаруй км ус дамжуулах шугам хоолой татах, дагалдах тоног төхөөрөмжийг суурилуулан, ус цэвэршүүлэх станцыг барих зорилгоор хэрэгжүүлж буй “Тайшир-Алтай” төслийн нээлтийг 2019 оны 04 сарын 29-ны өдөр зохион байгууллаа.

Уг төслийн ач холбогдол нь гадаргын усны тодорхой хэсгийг аж ахуйн эргэлтэд оруулан хүн ам, аж үйлдвэр, фермерийн ус хангамжийг шийдвэрлэхээс гадна Алтай хотын усны хэрэгцээг хангах, усны нөөцийн баталгаат эх үүсвэртэй болох, ундны усны хүртээмжийг нэмэгдүүлэх, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах юм.

Барилга, хот байгуулалтын яам нь Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн 40 авто машины зогсоолтой, 2 блок, 60 айлтай, 120 айлын орон сууцны барилга байгууламжийн нээлтийн үйл ажиллагаа 04 дүгээр сарын 29-нд зохион байгуулагдлаа.

Тус орон сууцны барилгын ерөнхий захиалагчаар Барилга, хот байгуулалтын яам, Санхүүжүүлэгч байгууллагаар Монгол Улсын Хөгжлийн банк, Захиалагчийн хяналт хэрэгжүүлэгч байгууллагаар “Төрийн орон сууцны корпорац” ТӨХХК, Ерөнхий гүйцэтгэгчээр “Хөх бүрдний эх” ХХК, Зураг төсөл зохиогчоор “Гандирс-Орд” ХХК, болон Аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох байгууллагуудтай хамтран ажилласан юм.

Одоогоор тус орон сууцны барилгыг иргэдэд олгох талаар Засгийн газраас тодорхой шийдвэр гаргаагүй хүлээгдэж байна.

Улсын 5,000.0 сая төгрөгийн санхүүжилтээр “Мандал голомт” ХХК-ий гүйцэтгэж буй “Дэлгэр сумын төвийн шинэчлэл төслийн явцад “Барилга, хот байгуулалтын яамтай хамтран гүйцэтгэлийн хяналтыг хийж мэргэжил арга зүйн зөвлөгөө, техникийн зөвлөмж өгч ажиллаа.

“Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-ын 9173ГАҮ, 8363ГАҮ, 2094ГАҮ, 4197УН, 2454ГАҮ, 2464ГАҮ, 2459ГАҮ, 2559ГАҮ, 9377АА улсын дугаартай автомашинуудыг 2019 оны тээврийн хэрэгсэлийн үзлэг оншилгоонд оруулж, 21-24ГАҮ Улсын дугаартай Тусгай зориулалтын усалгааний LGHXB1H4E6109715 арлын дугаартай, BJ1S2E72380 хөдөлгүүртэй авто машиныг “Ундарга-Алтай” ОНӨААТҮГ-аас хасалт хийлгэж Алтай хотын тохижилт үйлчилгээний газар хүлээлгэн өглөө.

“Алтай Улиастайн Эрчим Хүчний Систем” ТӨХК нь 4-р сард ЦДҮС, ББЭХС, Тайшир УЦС, Тосонцэнгэлийн УЦС, Улиастайн ДиЦС, Есөнбулаг ДиЦС сэргээгдэх эрчим хүч дизель генератор хосолсон нарны цахилгаан станц зэрэг эх үүсвэрүүдээр Говь-Алтай, Завхан аймгийн төвүүд болон 44 сум сууринг ЦЭХ-ээр тасралтгүй найдвартай ханган ажиллаж байна. Хоёр аймгийн хэмжээнд оргил ачаалал 13,1 МВт, бага ачаалал 5,3 МВт. 2 аймгийн хоногийн хэрэглээ 212,480 мян.кВт.цагт хүрч ажиллав. Хоногийн нийт хэрэглээний 60%-ийг худалдан авалтаар, 40%-ийг дотоодын үйлдвэрлэлтээр ханган ажиллалаа.

Оргил ачааллын үед Тайшир УЦС-5,5 МВт, Төвийн Бүсийн Нэгдсэн Сүлжээнээс 7,0 МВт, Баруун бүсийн эрчим хүчний системээс 0,8 МВт, Богдын голын УЦС 0МВт, Тосонцэнгэл УЦС 0,0 МВт, Улиастайн ДиЦС 0,3 МВт, Есөнбулаг ДиЦС 0.3 МВт, нарны цахилгаан станцаар 0,22 МВт-ыг гарган ажиллаж байна.

#### **Техник зохион байгуулалтын талаар:**

2019 оны 4-р сард хэрэглэгчдээс ЦЭХ-ний хангамж, гэмтэл сааталтай холбоотой 427 дуудлага хүлээн авч шуурхай ажиллагаагаар барагдуулсан. Үүнээс цахилгаан эрчим хүчний гэрээг 25 хэрэглэгчидтэй хийж гэрээ байгуулан холболт хийсэн.

- ✓ ТЗБАХ-н ажлын хүрээнд төлөвлөгөөнд тусгагдсан “Систем компанийн конторын барилгын гадна тохижилт, зам талбайн засварын ажил”, “Гүйдлийн трансформатор шалгах багаж”, “Аваарын нөөц бүрдүүлэх”, “Елегаз таслуур” гэсэн тендрүүдийг цахим тендэрт байршуулсан.
- ✓ Ерөнхий инженерээр ахлуулсан баг Шарга, Дарив, Хөхморьт, Тонхил, Баян-Уул, Дэлгэр, Гуулин, Тайшир сумуудад 3-р шатны үзлэг шалгалт хийсэн.
- ✓ Хяналтын инженерээр ахлуулсан баг Олоннуур -3 шитнээс тэжээгддэг айл өрх, Хосг-1 дэд станц, Баянхайрхан багийн хэрэглэгчидэд хяналтын үзлэг хийгдсэн.

#### **ЗУРГАА. ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР:**

Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 255 дугаар тогтоолоор батлагдсан “Эрүүл шүд-Эрүүл хүүхэд” үндэсний хөтөлбөрийн нээлтийг 4 дүгээр сарын 22-ны өдөр нээлтийн арга хэмжээг төв талбайд зохион байгууллаа.

Нээлтийн үйл ажиллагаанд III цэцэрлэг, I сургуулийн багачууд мэндчилгээ дэвшүүлэн, улсын тэргүүний I цэцэрлэгийн хүүхдүүд шүдээ тогтмол угааж байхыг оролцогчдод уриаллаа.

Тус хөтөлбөрийн хүрээнд 2-12 насны хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, эмчлэн эрүүлжүүлэх тусламж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх бөгөөд энэ онд 2-6 насны хүүхдүүд хамрагдана.Нэг хүүхдийн шүдийг бүрэн эрүүлжүүлэхэд дунджаар 60 мянган төгрөг зарцуулахаар тооцсон байна.

Манай аймгийн хэмжээнд 2-12 настай 12623 хүүхэд байгаа бөгөөд энэ онд 2-6 настай 5970 хүүхэд үзлэг шинжилгээнд хамрагдах юм.

➤ **“Цэвэр орчин-Эрүүл Алтай” аяны нээлтийг зохион байгууллаа.**

Иргэдийн оролцоотойгоор эрүүл, аюулгүй орчин бүрдүүлж, ус, хөрс, агаарын бохирдлыг бууруулан, орчны бохирдлоос шалтгаалсан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 2019 оны 4 дүгээр сарын 19-нөөс 11 дүгээр сарын 19 хүртэл зохион байгуулах “Цэвэр орчин-Эрүүл Алтай” аяны нээлтийг зохион байгууллаа. Тус аяныг Аймгийн ЗДТГ, ЭМГ, БОАЖГ, Хүйсийн говь цэцэг нуурын сав газрын захиргаа, Мэргэжлийн хяналтын газар хамтран зохион байгуулж байна.

**“Эх барихын яаралтай тусламж” ур чадварын сургалтын танхимтай боллоо.**

Манай аймагт ЭМЯ-ны Нөхөн үржихүйн тусламж үйлчилгээ, өсвөр үе хариуцсан мэргэжилтэн Д.Байгалмаа, НҮБ-ын Хүн амын сангийн шадар суурин төлөөлөгч А.Илиза, НҮБ-ын Хүн амын сангийн эх, нярайн төслийн удирдагч Б.Цэдмаа, НҮБ-ын Хүн амын сангийн санхүүгийн ажилтан Солонго, ЭХЭМҮТ-ийн их эмч, мэргэжилтэн Чинзориг нар ажиллаж, Нэгдсэн эмнэлгийн дэргэдэх амаржих газарт НҮБ-ын Хүн амын сангаас 38 сая төгрөгийн өртөгтэй 11 өртөө бүхий сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжийг олгон эмнэлзүйн танхим байгууллаа.

Түүнчлэн амаржих газрын эрчимт эмчилгээний өрөөнд Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвтэй 24 цагаар холбогдох боломжтой өндөр хүчин чадлын 360 градус эргэдэг камер, компьютер бүхий харилцааны лабораторийг тохижууллаа.

Ур чадварын танхимын нэгдсэн лабораторийг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвп байгуулсан бөгөөд эмчлүүлэгсдэд хүндрэл гарсан тохиолдолд орон нутгийн эмнэлгийн мэргэжилтнүүд ЭХЭМҮТ-тэй холбогдон видеогоор зөвлөгөө авах боломжтой юм.

Мөн нэгдсэн эмнэлгийн “Өсвөр үед зөвлөгөө өгөх кабинет”, Хамгаалах байрны үйл ажиллгаатай танилцаж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өглөө.

**Онол, практикийн бага хурал зохион байгууллаа.**

“Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо-2019” уриатай Олон улсын сувилагчдын өдрийг угтан “Нийгмийн эрүүл мэндийн сувилахуй” сэдэвт онол практикийн хурлыг 04 дүгээр сарын 19-ны өдөр зохион байгуулж, 30 сувилагч, тусгай мэргэжилтэн оролцон 12 илтгэл хэлэлцүүллээ. Үүнд:

I байр “Баруун 5 аймгийн иргэдийн монгол эмийн хэрэглээ, монгол эмийн талаарх мэдлэгийг судлах нь”- илтгэгч: УАУТ-ийн сувилагч О.Батчимэг

II байр “Гуурсан хоолойн багтраа, уушигны архаг бөглөрөлт өвчтэй хүмүүс ингиляциян кортикостеройд эмийн хэрэглээнд хийсэн судалгааны үр дүн”- НЭ-ийн дотрын тасгийн сувилагч Н.Мөнхзаяа

III байр “Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын айл өрхийн ундны усны саванд үнэлгээ хийсэн нь”- НЭ-ийн ЗАА тасгийн арга зүйч Х.Долгоржав нар тус тус шалгарлаа.

**“Нийгмийн эрүүл мэндэд сувилагч бидний оролцоо-Шинэ бүтээл -2019” уралдааныг зохион байгууллаа.**

Олон улсын сувилагчдын өдрийг угтан тус уралдааныг 04 дүгээр сарын 22-нд зохион байгуулж 7 тасгийн 13 бүтээл оролцсон бөгөөд I байр Г.Жаргал ахлагчтай 103

яаралтай тусламжийн тасгийн баг, II байр Н.Гэрэлмаа ахлагчтай хүүхдийн тасгийн баг, III байр Ц.Тунгаамаа ахлагчтай дотрын тасгийн баг тус тус шалгарлаа.Үүнд:

**Яаралтай тусламжийн ханын шкаф:** Үйлчлүүлэгчдэд хүргэх эмнэлгийн тусламжийн үйлчилгээний чанар сайжирна. / Андуурагдах эрсдэл, Ажлын орчны эмх цэгц сайжирна,Цаг хугацааны алдагдал багасана./

**Дуудлагын хонх** 9 өрөөнд 36 үйлчлүүлэгчийн мэдээлэл өгч байна. Сувилахуйн өрөөнд байрлуулсан суурин дэлгэцэнд өрөө бүрт байрлуулсан хонхыг дарахад мэдээлэл ирнэ.Одоогийн байдлаар 1 гэсэн тоо 4 өвчтний мэдээлэл дамжуулж байна.



**Зөөврийн хүчилтөрөгч:**Өвчтний биеийн байдлыг хэвийн хэмжээнд байлгах,хүчилтөрөгчийн аппарат хүрэлцээгүй болон залгуургүй байгаа үед хурдан хугацаанд зөөвөрлөн өгөхөд чухал ач холбогдолтой юм.

**Цэвэр маскны иж бүрдэл:** Хэвтэн эмчлүүлж байгаа үйлчлүүлэгч нартаа маскыг 2 цаг тутамд сольж зүүлгэж хэвшүүлж эхэллээ.

- 09 цагт улаан, 11 цагт ногоон, 13 цагт хүрэн,15 цагт цайвар ногоон, 17 цагт хөх, 19 цагт ягаан, 21 цагт улаан ягаан өнгийн тэмдэглэгээтэй маскыг зүүнэ.
- Үйлчлүүлэгч орой амрахаасаа өмнө 7 ширхэг маскаа угааж индүүдэж ариутгаж , хатааж ариун савандаа хийнэ.

**Эх, хүүхдийн тусламж, үйлчилгээг сайжруулах чиглэлээр сургалт зохион байгууллаа.**

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын Байгууллагын дэмжлэгтэйгээр "Жирэмсний хяналтыг сайжруулж, дутуу төрөлтөөс сэргийлэх" нь сэдэвт сургалтыг сум, тосгон, өрхийн Эрүүл мэндийн төв, Сум дундын эмнэлгийн дарга нарт зохион байгууллаа.

**Орчны эрүүл мэндийн сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа.**

Сургалтанд сум бүрээс Тамгын газрын дарга, Эрүүл мэндийн төвийн нийгмийн эрүүл мэндийн ажилтан, сайн дурын идэвхтнүүд болон ажлын хэсгийн 120 хүн хамрагдлаа. Тус сургагч багш нар орон нутагтаа очоод стандартын жорлон, бохирын цооног барих аргчлалыг заах бөгөөд аяны турш ард иргэдэд мэдээлэл сургалт, сурталчилгаа хийх юм. Сургалтанд ШУТИС-ийн багш, МУ-ын усны зөвлөх, доктор, профессор Д. Басандарж багш урилгаар хүрэлцэн ирж монголын цаг уурын нөхцөлд тохирох жорлонгийн шийдлүүд болон цэвэрлэх байгууламж, орчны эрүүл ахуйг сайжруулах арга зүйн зөвлөмж өглөө.

- **Эмийн сургалт:** “Denkpharma” ХХК-ны сургалтанд эмийн сангийн 18 мэргэжилтнүүдийг хамрууллаа.
- **Цахим төндөр зохион байгууллаа.**

Ерөнхий гэрээний 9 нэр төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн сонгон шалгаруулалтыг цахим тендэрээр зохион байгууллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комисс 4 дүгээр сарын 02-ны өдөр хуралдаж “Төгөлдөршил” ХХК-ийн Төгөлдөршил, “Гэгээн од хүслэн” ХХК-ийн “Гэгээн хүслэн” шүдний клиник, “Сутайн гурван хулд” ХХК-ийн “Эрхэт мед” клиник лабораторит тусгай зөвшөөрлийг олгон, “Түмэн туяа” ХХК-ийн “Түмэн туяа”, “Сант арвин” ХХК-ийн Ээлт эмийн сан, “Уудам алтай дент” ХХК-ийн Халиун шүдний эмнэлгийн тусгай зөвшөөрлийг хугацааг тус тус сунгалаа.

Халдварт өвчин судлалын үндэсний төв /ХӨСҮТ/, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв, Эрүүл мэндийн газар хамтран “Тарилгатай халдварт өвчний дархлал тогтоц, түүнд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлийн судалгаа, 2017-2019” сэдэвт ЭМЯ-ны захиалгат төслийг хэрэгжүүлж байна.Тус төслийн хүрээнд дараах арга хэмжээг зохион байгуулж байна.Үүнд:

-Хүн амын дундах тарилгатай халдварт өвчний дархлал тогтоцыг тодорхойлох зорилгоор түүврийн аргаар Баян-Уул, Бугат, Гуулин, Тайшир Тонхил, Цогт, Цээл, Эрдэнэ, Есөнбулаг сумдаас тус бүр 10 өрхийг сонгон, 06 сартайгаас 60 нас хүртэлх бүх иргэдийг судалгаанд оролцуулж 350 хүнээс цусны сорьц цуглуулж, асуумж судалгааг авч Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв болон Монолита лабораторид хүргүүллээ.

-Цочмог сул саажилтын тохиолдол болон эрүүл хүүхдийн өтгөний сорьцонд полиовирус илрүүлэх шинжилгээг 40 хүүхдэд хийхээр ЭМГ-ын албан бичгийг 3 өрхийн эрүүл мэндийн төвд хүргүүллээ.

-Заавал хийх товлал болон тархвар судлал, сайн дураар хийгдэх вакцин биобэлдмэлийн 2020 оны төлөвлөгөөг боловсруулж ХӨСҮТ-д хүргүүллээ.

Алтай сумын Эрүүл мэндийн төвийн өргөтгөл их засварын болон Шарга, Төгрөг, Халиун сумдын Эрүүл мэндийн төвүүдийн шинэ барилгийн тендер зарлагдахтай холбоотой техникийн тодорхойлолт, холбогдох материалыг бүрдүүллээ.

Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын орлого, зарлагын мэдээг Үндэсний статистикийн хорооны онлайн программд шивж илгээх ажлыг зохион байгуулж, 42 байгууллагын тайлан нэгтгэгдэхээс 97.7%-ийг хамрууллаа.

#### ДОЛОО.БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГ, ХАЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

ЭЕШ-ын монгол хэл, бичгийн шалгалтыг 2019 оны 03 дугаар сарын 23-нд багийн ахлагч, сэдэв хариуцагч, хянагч багш нарын ахлагч, 8 зохион байгуулагч, 48 хянагч багштай зохион байгууллаа. Монгол хэл, бичгийн шалгалтад 643 хүүхэд орохоос, 513 хүүхэд шалгалтад орж, 130 хүүхэд ирээгүйгээс ЭЕШ-д бүртгүүлээгүй-128, хүндэтгэх шалтгаантай-2, 79,7%-ийн ирцтэй шалгагдлаа.

ЭЕШ-2019 сорилго 3 дугаар сарын 11-15-ны өдрүүдэд явагдаж сорилгод элсэлтийн ерөнхий шалгалт өгөх 477 сурагч 11 хичээлээр хамрагдсан байна.

БСУГ-аас 5-р ангийн сурагчдын дунд жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ИЛТГЭЛ-н уралдаан амжилттай боллоо. Энэ жилийн илтгэл "ХҮҮХЭД ХҮҮХДЭЭСЭЭ СУРАЛЦЪЯ" сэдвийн хүрээнд зохион байгуулагдаж нийт 17 сургуулийн 32 хүүхэд багаараа болон ганцаарчлан оролцож 1-р байранд Жаргалан сумын сургуулийн Жаргалтуяа багшийн шавь Хонгорзул шалгарлаа.

"Зөвлөх, тэргүүлэх багшийн манлайлал" ажлын төлөвлөгөөнд тусгагдсан Байгалийн ухаан, Математик, Монгол хэлний багийнхны бэлтгэсэн сургалт амжилттай зохион байгуулагдлаа.

Бага ангийн багш нарынхаа БАГ олимпиадыг 4 дэх жилдээ амжилттай зохион байгууллаа.

"ЭЕШ-2019" аяны хүрээнд "НЭГ БАЙГУУЛЛАГА-НЭГ БҮТЭЭЛЧ АЖИЛ" арга хэмжээг 2019 оны 03 дугаар сарын 23-ны өдөр ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар анги төгсөгчдийн ажил мэргэжлийн сонголтод эерэг нөлөө үзүүлэхэд чиглэсэн танилцуулга, мэдээлэл, зөвлөх үйлчилгээг 13 байгууллагатай хамтран зохион байгууллаа.

2019 оны 3 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Есөнбулаг сумын 2 дугаар сургууль дээр биеийн тамирын багш олимпиад, "Сайн төлөвлөгөө-сайн гүйцэтгэл-амжилт" туршлага солилцох зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Зөвлөгөөнд 35, олимпиадад 28 нийт давхардсан тоогоор 63 мэргэжлийн биеийн тамирын багш оролцсон байна.

"Биеийн тамирын хэрэглэгдэхүүн бүтээлчээр ашиглах арга зүй"-н сургалтыг сургуулийн удирдлага нийт 35, төвийн бүсийн 15 багш болон орон нутгийн 11 багш хамруулан 3 удаагийн сургалтыг онол, дадлага хосолсон хэлбэрээр үр дүнтэй зохион байгуулан ажиллалаа.

"Оюунлаг-Алтай" хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулж буй Говь-Алтай аймгийн засаг даргын нэрэмжит "Алтайн залуу зохион бүтээгч-2019" уралдааныг 3 үе шаттайгаар зохион байгууллаа. Уралдаанд 16 сум, сургуулийн 41 багш, сурагч, 60 орчим бүтээлийн санаа танилцуулагдснаас 3-р шатанд 23 бүтээл шалгарсан. Шалгарсан бүтээлийг 3 дуаар сарын 26-нд эцсийн байдлаар дахин шалгаруулж 13 бүтээлээр үзэсгэлэн гаргаж олон нийтэд сурталчиллаа.

Уралдааны 1-р байрыг Халиун сумын багш Н.Жанчивдорж, сурагч Р.Рэнцэнбал нар "Шавар зуурагч" бүтээлээр, 2-р байрыг Цогт сумын багш Б.Рагчаа, сурагч Н.Төрмөнх нар "Усны сав тогтоогч", мөн Есөнбулаг сумын 3-р сургуулийн багш Ж.Энхбаатар, сурагч Б.Батзориг нар "Төмс суулгагч", "Түүгч" бүтээлээр, 3-р байрыг Дарив сумын багш Ц.Дэлгэр, сурагч Д.Бурмаа нар "Ааруул хатаагч", мөн Тонхил сумын багш Т.Энхжин, сурагч Өлзиймягмар нар "Хотны цан арилгагч" бүтээлээр, Тусгай байрыг Төгрөг сумын багш Д.Ичинхорлоо, сурагч Түвшиндалай нар "Сав угаагч, самбар арчигч", Есөнбулаг сумын 1 дүгээр сургуулийн багш Б.Амарсанаа, сурагч Сэргэлэн нар "Хялбар өргөгч", Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн багш Г.Жадамба, Х.Мөнх-Эрдэнэ нар "Уран хөрөөний суурь", Есөнбулаг сумын 3 дугаар сургуулийн багш Г.Даваадорж, сурагч Э.Бат-Оргил нар "Цас бутлагч" бүтээлээр тус тус шалгарчээ.

Улсын техник технологийн XXIII олимпиадын 9 төрөлд 42 багш, 67 суралцагч оюун ухаан, авхаалж самбаа сорин өрсөлдлөө.

Дүрслэх урлаг, дизайн технологийн багш нарын мэргэжил дээшлүүлэх "Бүрэн дунд боловсролын дизайн технологи хичээлийн агуулга, хэрэгжүүлэх аргазүй" сургалтад 51 багш хамрагдлаа.



Математикийн олимпиадад аймгийн төвийн сургуулиудаас 2 сурагч, сумдаас 1 сурагч оролцлоо. 7-р ангид нийт 23 сурагч, 8-р ангид 23 сурагч, 9-р ангид 24 сурагч, 10-р ангид 21 сурагч, 11-р ангид 16 сурагч, 12-р ангид 17 сурагч, математикийн дунд ангийн багш ангилалд нийт 37 багш, бага ангийн багш ангилалд 36 багш оролцож нийт математикийн улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд 197 багш сурагчид хамрагдлаа.

Физикийн улсын төрөлжсөн олимпиадыг 2019 оны 04 сарын 08-ны өдөр Есөнбулаг сумын 2-р сургууль дээр зохион байгуулж явууллаа. Олимпиадад 7-р ангийн 21, 8-р ангийн 20, 9-р ангийн 21, 10-р ангийн 13, 11-р ангийн 14, 12-р ангийн 13, Багш-24 гэсэн нийт 7 ангиллаар 126 багш сурагчид хамрагдлаа.

Сэтгэх чадварын улсын төрөлжсөн олимпиадыг 2019 оны 04 сарын 08-ны өдөр Есөнбулаг сумын 2-р сургууль дээр зохион байгуулж явууллаа. Мөн Оюунлаг-Алтай хөтөлбөрийн хүрээнд цэцэрлэг болон 1-р ангийн сурагчдын дунд сэтгэх чадварын олимпиадыг зохион байгууллаа. Уг олимпиадад аймгийн төвийн сургуулиудаас 2 сурагч сумдаас 1 сурагч оролцлоо. Цэцэрлэг ангилалд-28,1-р ангид 29, 2-3-р ангид 31, 4-5-р ангид 31, 6-7-р ангид 29, 8-9-р ангид 28, 10-11-р ангид 25, 12-р ангид 15, Бүтээлч багшид 15 оролцож нийт Сэтгэх чадварын улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд 231 багш сурагчид хамрагдлаа.

Математикийн багш нарын “Хамтдаа хөгжье” сургалтад 45 багш хамрагдлаа. Сургалтад ЭЕШ-ын 3 сарын аяны үр дүн, 2016-2018 оны ЭЕШ-ын дүн шинжилгээ, даалгаврын шинжилгээ, ЭЕШ-нд бэлтгэх арга туршлага, олимпиадад бэлтгэх арга туршлага, жишиг даалгаврын шинжилгээ, зөвлөх багшийн туршлага, багш нарын багийн хамтын ажиллагаа, математикийн сургалтын чанарыг сайжруулах боломж, хөндлөнгийн үнэлгээний шалгалтын үр дүн зэрэг агуулгын хүрээнд нэлээд багш нар хэрэг болохуйц үр дүнтэй сургалт боллоо. Сургалтад Есөнбулаг сумын 1-р сургуулийн зөвлөх багш Н.Доржмаа өөрийн арга туршлагаасаа хуваалцлаа.

Мэдээллийн технологийн улсын төрөлжсөн олимпиадыг 2019 оны 04 сарын 10-ны өдөр Есөнбулаг сумын 1-р сургууль дээр зохион байгуулж явууллаа. Уг олимпиадад аймгийн төвийн сургуулиудаас 2 сурагч, сумдаас 1 сурагч оролцлоо. 10 хүртэлх ангид 13 сурагч, 11-12-р ангийн ангилалд 12 сурагч, багш ангилалд 9 багш нийт мэдээллийн технологийн улсын төрөлжсөн олимпиадын 2-ын даваанд 34 багш сурагчид хамрагдлаа.

2019 оны 02 сарын 14-нээс 04 сарын 15-ны хооронд элсэлтийн ерөнхий шалгалтын бүртгэл хийж, 529 шалгуулагч бүртгүүлсэн. Үүнээс 484 энэ оны төгсөгч, 45 өмнөх оны төгсөгч бүртгүүлсэн.

МУИС, АШУУИС-ийн сургалтын албанаас 12 дугаар ангийн сурагчдад мэдээлэл сургалт зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 18 сургуулийн сурагч 12 дугаар ангийн багш, сургуулийн захирлууд хамрагдсан.

Дэлхийн байгаль хамгаалах сан(WWF)-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын "Ирвэстэй нутгийн ирээдүй" төслийн хүрээнд зорилтот бүс нутгийн сурагчдад цоохор ирвэс түүний идэш тэжээл бологч амьтдын байгаль дахь үнэ цэнэ, ач холбогдлыг ойлгуулах, танин мэдүүлэх замаар "Тогтвортой хөгжлийн боловсрол"-ыг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх зорилготой "Зорилтот бүс нутгийн сургуулийн багийг чадавхжуулах" сургалт 2019 оны 04-р сарын 12-15-ныг дуустал БМДИ дээр зохион байгуулагдлаа. Сургалтад ирвэсийн бүс нутаг болох Жаргалан, Шарга, Дарив, Баян-Уул сумдын бага боловсролын багш, хими биологи болон ЭКО клуб хариуцсан багш, сургалтын менежер, Боловсрол, соёл урлагийн газрын бага боловсрол, хими биологи хариуцсан мэргэжилтэн нийт 14 хүн хамрагдлаа.

### НАЙМ. НИЙГМИЙН ДААТГАЛ, ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР

2019 оны 04 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст нийт дараах аж ахуй нэгж байгууллагаас сул чөлөөтэй ажлын байрны захиалга ирсэн байна.

- MCS-ТОТАЛ ДИСТРИБЮШИН ХХК Барилгын хяналтын инженер
- Аймгийн нэгдсэн эмнэлэгт хүний нөөцийн менежер
- Есөнбулаг сумын 4 дүгээр сургууль дараах ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж байна.
  1. Монгол хэл, уран зохиолын багш-1
  2. Химийн багш-1
  3. Биологийн багш-2
  4. Дизайн технологийн багш /эр/-2
  5. Дуу хөгжмийн багш-2
  6. Биеийн тамирын багш-3
  7. Сэтгэлзүйч-1
- Алтайн Хүдэр ХХК-аас ирүүлсэн ажлын байрны захиалгуудын дагуу орон нутгийн 20 иргэнийг ажилд зуучилсан байна.

"Марко Поло" ХХК туслах ажилтан ажилд авахаар захиалга ирүүлсний дагуу 7 иргэнийг санал болгосон байна.

Ардын Дуу Бүжгийн Алтай чуулгаас жолооч, няравын ажлын байрны захиалга ирүүлснийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээлэв.

Аймгийн ХХҮГазар МСҮТөвтэй хамтран ажиллах 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгасны дагуу МСҮТөвийн 1 жилийн мэргэжлийн ангийг цахим тоног төхөөрөмжийн үйлчилгээний ажилтан, мэргэшсэн жолооч, үсчин, үйлдвэрийн механик, хүнд машин механизмын оператор зэрэг мэргэжлээр төгсөж буй 39

сурагчдад ХХҮГарзаас тухайн онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр болон газрын дэргэдэх залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих загвар төвийн үйл ажиллагааны талаар зөвлөгөө мэдээлэл өгч АЖЛЫН ХӨТӨЧ гарын авлагыг хүргэн ажиллалаа.

Гомбын нэрэмжит улсын тэргүүний 1 дүгээр сургууль болон шинээр байгуулагдсан 4 дүгээр сургуулийн захирлуудтай уулзаж, Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн судалгаанд сургууль, багш, ажилчид, ахлах ангийн сурагчдыг хэрхэн хамруулах, АМЧБО /ажил мэргэжлийн чиг баримжаа олгох/ сургалтыг нийтэд нь бус анги ангид нь чанартай зохион байгуулж хамтарч ажиллах тухай ярилцан ажлын төлөвлөгөө гаргалаа. Мөн ахлах ангийн сурагчдад зориулан 19 салбарын 500 мэргэжлийн дэлгэрэнгүй танилцуулгатай "АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ЛАВЛАХ ТОЛЬ"-ийг гарын авлага болгон өглөө.

Ажилгүйдлийн тэтгэмжийн тодорхойлолтыг 9 иргэн авсан байна.

2019 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр зарлагдаж байна.

Төсөл хүлээн авах хугацаа: 2019 оны 04 сарын 22-ны өдрөөс 04 сарын 26-ны 18:00 цаг

### **НИЙГМИЙН ХАЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ**

2019 оны 4 дүгээр сард дараахь тэтгэвэр тэтгэмжийг иргэдэд олгосон.

- Халамжийн тэтгэвэр 1302 иргэнд 226,1 сая.төг
- Нөхцөлт мөнгөн тэтгэмж 865 иргэнд 61,2 сая.төг
- Амьжиргаа дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж 181 иргэнд 27,8 сая.төг
- Ахмад настны хөнгөлөлт тусламж 28 иргэнд 3,9 сая.төг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөнгөлөлт, тусламж 93 иргэнд 5,2 сая.төг
- Жирэмсэн эхийн тэтгэмж 518 иргэнд 18,8 сая төгрөг
- Алдарт эхийн одонтой 4 эхэд 0,5 сая төгрөг
- Цалинтай эхийн тэтгэмж 2618 иргэнд 130,0 сая төгрөг
- Өрх толгойлсон эх эцэгт олгох тэтгэмж 1 иргэнд 0,2 сая төгрөг
- Алдар цолтой ахмадын хөнгөлөлт 30 иргэнд 4,7 сая.төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлсэн.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага байгуулагдсаны 100 жил, монгол улсад хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага бие даан байгуулагдсаны 60 жилийн ой тохиолдуулан аймаг, дүүргийн ххүг, хэлтсүүдийн дунд сагсан бөмбөг болон гар бөмбөгийн тэмцээнийг ХНХЯамнаас бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулж байгаа бөгөөд тус аймагт 2019.04.20-21-ны өдрүүдэд зохион байгуулж байна. Наадмын нээлтэд Говь-Алтай аймгийн ИТХ-ын дарга Ж.Батжаргал, ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга М.Эрдэнэбилэг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны ахлах мэргэжилтэн П.Хишигжаргал, Говь-Алтай аймгийн болон оролцогч аймгуудын ХХҮГ-ын дарга нар оролцож баг тамирчдад амжилт хүслээ.

Спортын наадамд Баянхонгор, Завхан, Говь-Алтай, Увс, Ховд, Баян-Өлгий аймгийн хөдөлмөр нийгмийн хамгааллын салбарын 120 гаруй алба хаагч өргөн бүрэлдэхүүнээрээ оролцож байна. Тэд энэ амралтын өдрүүдэд волейбол, сагсан бөмбөгөөр өрсөлдөж тавдугаар сарын 10, 11-ний өдөр нийслэлд болох улсын аваргад оролцох шилдгүүдээ шалгаруулна.

Шинээр тэтгэвэр тогтоолгосон хүсэлт гаргасан сум, аймгийн төвийн тахир дутуугийн 11, өндөр нас 5, нийт 16 тэтгэврийн материал хүлээн авч хуулийн хүрээнд шийдвэрлэлээ. Тэтгэмжийн зардал ажилгүйдэл 10 хүнд 5670,0 мянга, жирэмсэн

амаржсаны 17 хүнд 20199,0 мянга, хөдөлмөрийн чадвар алдалт 12 хүнд 1569,0 мянган төгрөгийн зардал гарчээ. Оршуулгын тэтгэмж 5 хүнд 5 сая төгрөг олголоо.

Эрүүл мэндийн даатгалын орлого Есөнбулаг сумын хэмжээнд 58 хүн хамрагдсан байна. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 56 хүн орж 4 хүн цуцлагдаж 51 хүн сунгагдлаа.

## ЕС. ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ЧИГЛЭЛЭЭР

“Алтайн баялаг залуус” хөтөлбөрийн хүрээнд УИХ-ын гишүүн, Хууль зүйн, байнгын хорооны дарга Ш.Раднаасэдийн дэмжлэгтэйгээр Аймгийн Засаг даргын Тамгын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газар, Боловсрол соёл урлагийн газар, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, Насан туршийн боловсролын төв, аймгийн Залуучуудын холбоо, хамтран зохион байгуулж байгаа “Залуусын хөгжил-Бидний ирээдүй” аяны нээлт 04 дүгээр сарын 01-ний өдөр Есөнбулаг сумд нээлтийн арга хэмжээгээ хийж 650 залууг хамруулсан тус аян бүх сумдад очиж 04 сарын 19 нд Халиун сумд өндөрлөлөө. 24 хүний бүрэлдэхүүнтэй баг 20 хоногийн туршид бүх сумдын 4200 гаруй өсвөр үе, залуучуудад соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх хөгжлийн үйлчилгээг хүргэхээс гадна ГХУССЗ, Хүүхдийн төлөө зөвлөл, Хамтарсан баг, Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл, ИТХ-ын тэргүүлэгчдийг ажлын байранд нь чадавхжуулах сургалтыг зохион байгуулж 630 төрийн албан хаагчийг хамруулж, хамтарсан багийн үйл ажиллагаанд хяналт үнэлгээ хийлээ.

Түүнчлэн Эрүүл мэндийн газар, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагатай хамтран элэгний В,С вирусийн илрүүлэг, Хеликобактерийн шинжилгээнд 3000 орчим хүнийг үнэ төлбөргүй хамруулж аюулын харанга дэлдэж буй хорт хавдар болон бусад өвчлөлөөс урьдчилан сэргийлэх боломжийг таниулан сурталчиллаа.

Сургалт семинар, урлаг соёлын арга хэмжээ сүлэлдэн явснаараа онцлогтой байлаа.

Говь-Алтай аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Гоо даль эмэгтэйчүүдийн клуб, Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд ТББ хамтран Залуу эмэгтэйчүүдийн хөгжлийн хөтөлбөрийг 4 сарын 1- 6 сарын 1-ний хооронд 2 сарын хугацаатай хэрэгжүүлж байна. Сургалтанд 30 залуу бүсгүй хамрагдаж байгаа бөгөөд сэтгэлзүй, хувь хүний хөгжил, гадаад хэлний сургалтад хамрагдахаас гадна бүжиг, фитнес, иогоор хичээллэж, Эрсдэлт нөхцөл дэх хүүхэд, зорилтод өрхийн гэр бүл рүү чиглэсэн 3 төслийг хэрэгжүүлж байна. 04 дүгээр сарын 1-ны өдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар Нээлтийн арга хэмжээг зохион байгуулж урилгаар Сэтгэлийн өнгө ТББ-ийн тэргүүн Сэтгэл зүйч доктор Г.Наранбаатар Залуусын хөгжилд- Бидний оролцоо сэдэвт лекцээ уншиж, бүсгүйчүүдтэй чөлөөт ярилцлага хийлээ.

Оюутан залуусын өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлэх, үзэл бодлоо илэрхийлэх, тэдний дуу хоолойг олон нийтэд хүргэх, цаашид оюутан залуучуудын хандлага, харилцаанд нөлөөлж, эерэг өөрчлөлт бий болгох зорилгоор Говь-Алтай аймгийн аварга шалгаруулах уран илтгэлийн “ОЮУТНЫ ОЮУНЫ ДАВАЛГАА” тэмцээнийг АШУҮИС-ийн Говь-Алтай дахь Анагаах Ухааны сургуулийн оюутан залуусын дунд 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулж тэмцээнд түрүүлсэн оюутан Улаанбаатар хотод зохион байгуулагдах дараагийн шатанд оролцох эрхийг авсан.

Шинэ зууны хүүхэд, залуусын эрэлт хэрэгцээнд нийцсэн хөгжлийн үйлчилгээний арга зүйг хэрэгжүүлэх зорилгоор хүүхдийн хөгжлийн талаарх онол, үзэл баримтлалын өөрчлөлт, хандлагын талаар ойлголт өгөх, шинэ зууны хүүхэд залуусын эрэлт хэрэгцээ, эзэмшвэл зохих ур чадваруудыг хөгжүүлэх, дэмжихэд чиглэсэн арга зүйг таниулах, хүүхэд бие даан хөгжих оролцоонд суурилсан хөгжлийн хөтөлбөрийг боловсруулах арга зүйд сургах зорилтын хүрээнд Unicef-ийн дэмжлэгтэйгээр “МИНИЙ ЕРТӨНЦ”, “МИНИЙ ГЭР БҮЛ” хүүхдийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах менежер бэлтгэх сургалтыг 04 сарын 08, 09-ний өдрүүдэд зохион байгууллаа. Сургалтад 18 сум 2 тосгоны боловсролын нийгмийн ажилтан хүүхэдтэй ажиллагсад нийт 30 хүн хамрагдлаа.

Өсвөрийн Морин хуурчдын Улсын анхдугаар уралдаан Улаанбаатар хотод зохион байгуулагдаж Говь-Алтай аймгийн ГБХЗХГ-ын дэргэдэх "Хишигтэн" хамтлаг амжилттай оролцож, бага насны ангилалд ХЭЦ сургуулийн сурагч А.Амин-Эрдэнэ тусгай байр, дунд насны ангилалд 1-р сургуулийн сурагч Ж.Идэрсүрэн түрүүлж, ХЭЦ сургуулийн Н.Бат-Эрдэнэ, Цэрэндондов нар тусгай байр, ахлах насанд 1-р сургуулийн сурагч Ч.Батсүрэн 2-р байр эзэллээ. Нас бүрийн тэргүүн байр эзэлсэн хуурчдыг 1,5 сая төгрөгийн үнэ бүхий мэргэжлийн морин хуураар шагналаа. Мөн МУСТА Доржготовын Баянмөнх морин хуурын "Шилдэг багш" -аар шалгарч шагнал хүртлээ.

Зохиолч Луужирын Жиймий, Сайхан бүсгүй группийн админ Дээгийтэй хамтран “Намайг өөрчилсөн 85-н эмэгтэй” нэртэй 85-н хүчирхэг эмэгтэйн алдсаны эцэст оносон, ажилласаны эцэст амжилтанд хүрсэн, хүсэл мөрөөдөлдөө бууж өгөөгүй учраас хүрэхийг хүссэн байр сууриа эзэлсэн гэх мэт бодит амьдралаас урган гарсан эргэцүүлэл, бодрол, өгүүлэл багтсан номыг эрхлэн гаргасан. Энэхүү номыг нээлтийг 2019 оны 04-р сарын 13-ны өдөр Хүүхэд Залуучуудын ордонд “Гоо Даль” эмэгтэйчүүдийн групптэй хамтран зохион байгууллаа. Нээлтэнд урилгаар Хуульч, өмгөөлөгч Бархаагийн Болормаа, АШУҮИС-ийн багш Уламжлалын их эмч Баттулгын Цэцэгмаа нар оролцож бүсгүйчүүдтэй халуун дулаан яриа өрнүүлж, өөрсдийн амьдралдаа баримталдаг зарчим, бахархан үлгэрлэдэг хүмүүс болон амжилтанд хүрсэн, өөрийгөө ялан дийлсэн сонирхолтой түүхээс хуваалцсан юм.

Хүүхдийг хайрлан хамгаалах, чиглүүлэх, хүндэтгэн дагуулах, туслан дэмжих буюу хүмүүжлийн эерэг аргын талаар эцэг эхэд мэдээлэл өгөх, идэвхжүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдэд “Хүүхдийг хүмүүжүүлэх эерэг арга”-аар 2019 оны 04-р сарын 24-26-ны өдрүүдэд сургалт зохион байгууллаа. Сургалтанд нийт 94 эцэг эх оролцлоо.

18 сум 2 тосгоноос хараа хяналтгүй хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн судалгааг загвар хүснэгтийн дагуу авч, шаардлагатай байгаа үйлчилгээг үзүүлж, 3-р сургуулийн хараа хяналтгүй 2 хүүхдийг 1-р сургуулийн дотуур байранд оруулж, хөгжлийн бэрхшээлтэй 5 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт оруулж хөгжлийн бэрхшээлийг тодорхойлуулж, ДЗөн ОУБ-аас 2 хүүхдийн ар гэрт тус бүр 90000 төгрөгийн хүнсний талоны тусламжийг үзүүлсэн.

### АРАВ.БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЧИГЛЭЛЭЭР

Говь-Алтай аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор батлагдсан “Архигүй –Алтай хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах зорилгоор аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль зүйн хэлтсээс зохион байгуулж буй “Архигүй орчин-Архидан согтуурахын эсрэг

хамтдаа” аяны хүрээнд БОАЖГ-аас бодлогын шинж чанартай 2, олон нийтийг хамарсан 1 арга хэмжээг зохион байгуулж аяныг сурталчлах уриалгын зурагт хүрээг хийлгэн тугийг дагалдуулан 2019 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр Боловсрол, соёл, урлагийн газартхүлээлгэн өглөө. Олон нийтийг хамарсан “Эх дэлхийн цаг-2019” арга хэмжээний үеэр “Архигүй орчин-Архидан согтууралтын эсрэг хамтдаа” уриатай сурталчилгааны зурагт самбарыг аялуулан 90 гаруй иргэнд мэдээлэл хийсэн нь үр дүнгээ өгч, иргэд сурталчилгааны самбарт зургаа авахуулан аянд нэгдэж байгаагаа илэрхийллээ.

2019 онд Говь-Алтай аймгийн Алтай, Эрдэнэ, Цогт, Бугат, Тонхил, Баянхонгор аймгийн Баян-Өндөр, Шинэ-жинст, Ховд аймгийн Алтай, Булган, Үенч нийт 3 аймгийн 10 сумдад Герман, Монголын хамтарсан "KFW"-н "Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох нь" хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжихээр болсон.2019 оны 04 дүгээр сарын 01-03-ны өдрүүдэд тус төслийн хэлэлцүүлгийг аймгийн ЗДТГ болон БОАЖГ хамтран Алтай хотод зохион байгууллаа. Уг хэлэлцүүлэгт аймаг, сумдын төлөөлөл 70 гаруйажилтан албан хаагчид оролцож санал бодлоо солилцлоо. Энэ төсөл нь 2019-2025 оны хооронд хэрэгжих бөгөөд төслийн менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлж ажиллах 23 хүний бүрэлдэхүүнтэй зөвлөл байгуулагдаж зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зөвлөлийн даргаар Говь-Алтай аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Д. Батмагнай сонгогдлоо.

Улсын ГХУСАЗЗ, БОАЖЯ, ЦЕГ, ПЕГ, МХЕГ, ДБХС хамтран улсын хэмжээнд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлх зорилгоор 2019 оны 04 дүгээр сарын 15-аас 05 дугаар сарын 15-ныг хүртэл "Байгалиа хамгаалъя" сарын аяныг орон нутгийн хууль хяналтын байгууллагуудтай БОАЖГ хамтран зохион байгуулж байна. Аяны хүрээнд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотой хууль бус үйлдлийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр хянгалт шалгалтын ажлыг зохион байгуулах, хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын хэргийн шийдвэрлэлт, илрүүлэлтийг ахиулах, иргэд, олон нийтэд хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг таниулах, сурталчлах, ухуулга нөлөөл, мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулах юм.

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Ховд дахь салбартай БОАЖГ хамтран 2019 оны 04 дүгээр сарын 27-28-ны өдрүүдэд Төгрөг сумд Ховор, нэн ховор амьтдыг хамгаалах чиглэлээр “Бөхөнгийн нэг өдөр” арга хэмжээний хүрээнд “Говийн нүдэн булаг бөхөнгийн усаа хамгаалъя” уриан дор бөхөн бүхий сумдын эко клубын 150 гаруй сурагчдын уулзалт, өдөрлөгийг зохион байгуулж мэдээлэл сурталчилгаа хийлээ.

04 дүгээр сард Бигэр сумын нутаг дэвсгэрт XV017795 ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй “Металл эрэл хайгуул” ХХК, Бигэр, Есөнбулаг сумдын нутагт MV-00021243, XV-00015337 дугаартай хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Марко поло” ХХКмөн Бугат сумын нутаг дахь “Өндөр Алтайн зам” ХХК-ий 2019 онд БОАЖГ-аас ус ашиглуулах дүгнэлтийг тус тус гарган хүргүүлж ажиллалаа.

Алтай хотын агаарт агуулагдаж байгаа хүхэрлэг хий /SO<sub>2</sub>/ болон азотын давхар исэл /NO<sub>2</sub>/-ийн хэмжээг 08, 14, 20 цагуудад тогтмол хэмжиж хэмжлийн үр дүнг 10 хоног тутам нэгтгэн УЦУОШТ-ийн цахим хуудсанд байршуулан ард иргэдэд мэдээллээ.

УЦУОШТ нь гадаргын усны шинжилгээ 4 дүгээр сарын 01-ээс хийгдэж эхлэхтэй холбогдуулан бэлтгэл ажлыг хангах зорилгоор шинжилгээ хийхэд шаардлагатай калибровкуудыг тогтоох ажил хийгдлээ. /Аммоний-NH<sub>4</sub>, фосфор-P/, /Сульфат-SO<sub>4</sub>, Нитрат NO<sub>3</sub> /, . /Фтор-F/ натрийн тиосульфат -Na<sub>2</sub>S<sub>2</sub>O<sub>3</sub>, Трилон Б, Калийн перманганет-KMnO<sub>4</sub>- нормалийг тогтоож ажилласан байна.

2019 оны 04 дүгээр сарын 12-нд УЦУОШТ-өөс Тайшир сумын Завхан-Тайширын гол, Дэлгэр сумын Тайгам-Нуураас усны дээж авч химийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн байна.

Говь-Алтай аймгийн Ус цаг уур орчны шинжилгээний төвийн Алтай бороо-1, Алтай бороо-2 -экспедицүүд 2019 оны 04 сарын 08 наас 04 сарын 09 ны хооронд Цаг агаарт зориудаар нөлөөлөх ажиллагаа явуулж нийт сумдаар хур тунадас орлоо. Алтай бороо 1” экспедиц Төгрөг, Бугат, Цээл, Цогт сумдаар 2019 оны 04 дүгээр сарын 25-наас цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх ажлаар ажлын хэсэг ажиллаж байна.

#### **Уул уурхайн салбарт:**

4-р сард түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн 11 өргөдөл ирсэнийг уул уурхайн кадастрын системд шивж хуулийн хүрээнд арга хэмжээг аван ажилласан.

2019.04.22 – 2019.04.23 өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Нээлттэй, ил тод гэрээ” сэдэвт уул уурхайн хэлэлцүүлэгт ЗДТГ-ын дарга Ч.Бат-Эрдэнэтэй хамт оролцсон.

2019.04.24 – 2019.04.26 хооронд Швейцарийн Хөгжлийн Агентлагийн “Тогтвортой Бичил Уурхай” төслийн зохицуулах зөвлөлтэй уулзаж 2019 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээг хэлэлцэн төлөвлөж ажилласан.

2019.04.10-с 12 өдрүүдэд МХГ, БОАЖГ, ХГЦНСГ-тай хамтран Тонхил сумын Бүс Уул багийн иргэдийн нийтийн хуралд оролцож уул уурхайн салбарын хууль тогтоомж, түүний хэрэгжилтийн талаар мэдээлэл өгч тухайн нутагт үүсээд буй нөхцөл байдалд зөвлөгөө өгч ажиллалаа.

#### **АРВАН НЭГ. БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ЧИГЛЭЛЭЭР:**

2019.04 сарны 02-09-ний өдрүүдэд Ховд аймгийн Ховд хотод зохион байгуулагдсан волейболын спортын олон улсын хэмжээний мастер С.Кенесханы нэрэмжит “Ховд-2019” Идэрчүүдийн волейболын монгол улсын аварга шалгаруулах тэмцээнд ОУХ-ний мастер Ж.Уранчимэг, спортын мастер Ж.Болдцэцэг, спортын дэд

мастер Х.Баянтуул нарын дасгалжуулагчтай Говь-Алтай аймгийн БТСГ-ын эрэгтэй, эмэгтэй өсвөрийн шигшээ багийн тамирчид оролцож эмэгтэй баг тамирчид шилдэг 8-д шалгарч өнгөрсөн жил шилдэг 4-т шалгарч байсан эрэгтэй баг тамирчид амжилтаа ахиулж хүрэл медалийн болзол хангаж волейболын спортын түүхэнд байгаагүй сайхан түүх биссэн юм.

2019 оны 04 сарын 04-06-ны Завхан аймгийн Улиастай хотод болсон Жүдо бөхийн өсвөр үеийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд 5 аймгийн 300 гаруй тамирчид өрсөлдлөө. Тус тэмцээнээс Говь-Алтай аймгийн өсвөрийн шигшээ багийн 58 тамирчид оролцож 7 алт, 4 мөнгө, 15 хүрэл медаль хүртэж эмэгтэй багийн нийлбэр дүнгээр 2-р байранд шалгарлаа. Мөн эмэгтэй шилдэг тамирчнаар Б.Алтангэрэл шалгарлаа.

2019 оны 04 дүгээр сарын 13-14-нд Ховд аймагт зохион байгуулагдсан Хүүхдийн спортын 6-р их наадмын Таеквондоогийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээнд Говь-Алтай аймгийн БТСГ-ын өсвөрийн шигшээ багийн тамирчид амжилттай оролцож 4 алт, 6 мөнгө, 16 хүрэл медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 2-р байранд орлоо.

Говь-Алтай аймгийн Тайшир сумын ИТХ, ЗДТГазар, "Тайширийн Хүчтэнүүд" Үндэсний бөхийн холбоо, БТСГазар, Үндэсний бөхийн холбоотой хамтран зохион байгуулсан "Хөх төвд майнинг" ХХК-ийн нэрэмжит 2019 оны багийн аймгийн аварга шалгаруулах барилдаан 2019 оны 04 дүгээр сарын 12-нд Тайшир сумын төвд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус барилдаанд 11 сумын 48 сумын цолтой болон залуу бөхчүүд оролцон барилдлаа. Сумын заанууд хувийн дүнгээр 1-р байр: Ч.Алтай-Очир Эрдэнэ сум 2-р байр: Э.Жүгдэрнамжил Тайшир сум 1-р баг 3-р байр: С.Жаргалзаяа Есөнбулаг сум 1-р баг 4-р байр: Ц.Гомбо Тайшир сум 2-р баг 5-р байр: Д.Цэрэндэндэв Дэлгэр сум 1-р баг 6-р байр: Д.Алтаншагай Жаргалан сум

Сумын харцага, начингууд хувийн дүнгээр

1-р байр: Г.Дамбийбалжир Тайшир сум 1-р баг

2-р байр: М.Арсланбямба Тайшир 2-р баг

3-р байр: С.Бат-Эрдэнэ Бигэр сум

4-р байр: Г.Бат-Эрдэнэ Дэлгэр сум 1-р баг

5-р байр: Э.Цог Есөнбулаг сум 1-р баг

6-р байр: Г.Баасандаш Есөнбулаг сум 2-р баг

Залуу бөхчүүд хувийн дүнгээр

1-р байр: Г.Жанцанноров Тайшир сум 1-р баг

2-р байр: Ц.Эрдэнэчулуун Есөнбулаг

3-р байр: Б.Гунгаадорж Дэлгэр сум

4-р байр: Б.Дашдаваа Шарга сум

5-р байр: Баасандорж Тайшир сум

6-р байр: Г.Мягмарсүрэн Бигэр сум

БАГИЙН ДҮНГЭЭР

1-р байр: Б.Цэдэвсүрэн дасгалжуулагчтай сумын заан Э.Жүгдэрнамжил ахлагчтай Тайшир сумын 1 дүгээр баг.

2-р байр Л.Ганхуяг дасгалжуулагчтай сумын заан Ц.Гомбо ахлагчтай Тайшир сумын 2-р баг

3-р байр: Б.Баянзул дасгалжуулагчтай сумын заан С.Жаргалзаяа ахлагчтай Есөнбулаг сумын баг

4-р байр: Б.Нямжаргал ахлагчтай Дэлгэр сум тус тус эхний 4-н байр эзэллээ.

Хаалтын 32 бөхийн барилдаанд

Бигэр сумын харъяат аймгийн харцага Н.Батсайхан түрүүлж, Бигэр сумын харъяат



аймгийн онцгой байдлын газрын бөх аймгийн начин С.Содбаяр үзүүрлэж, Шарга сумын харъяат "Мөрөн-Алтай" ххк-ын бөх аймгийн начин Б.Төрмөнх, Тайшир сумын харъяат сумын заан Э.Жүгдэрнамжил нар их шөвгийн 4-т шалгарлаа.

Насанд хүрэгчдийн 2019 оны аймгийн аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээн 2019 оны 04 дүгээр сарын 20-нд амжилттай зохион байгуулагдаж өндөрлөлөө. Тус тэмцээнд эрэгтэй 15, эмэгтэй 13 нийт 28 тамирчин оролцлоо.

### АРВАН ХОЁР. ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР

СХЗГазрын Стратеги бодлого төлөвлөлт , дотоод аудитын газрын дарга С.Ням-Эрдэнэ, эдийн засагч Ч.Чимгээ, ахлах мэргэжилтэн Ц.Булганчимэг нар 04 дүгээр сарын 21-24 хооронд аймагт ирж ажиллан Стандарт, хэмжил зүйн хэлтсийн үйл ажиллагаа болон санхүүгийн баримт бичигт дүн шинжилгээ хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

Даралтын хэмжлээр 9 ширхэг 3 техникийн манометр, 22 ширхэг жинг баталгаажууллаа.

Цахилгааны хэмжлийн төрлөөр 1 фазын цахилгаан механик тоолуур 4 ширхэг 3 фазын цахилгаан механик тоолуур 2 ширхгийг баталгаажуулалт хийлээ.

Эзэлхүүн хэмжлийн төрлөөр түгээгүүр 8 ширхгийг баталгаажуулалт хийлээ.

Баталгаажуулалтын алба нь: Есөнбулаг, Цээл, Баян-Уул сумдын 2 нэрийн 14 худалддаа үйлчилгээний газраас тохирлын гэрчилгээ сунгуулах хүсэлтийг хүлээн авч 4 гэрчилгээг сунгаж, 10 гэрчилгээнд орон тооны бус баталгаажуулалтын зөвлөлийн хурлаар оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Стандартын салбар сан нь: "Уламжлалт анагаах ухааны төв", "Марал-Алтай," "Жаргалан-Алтай", "Энх-Алтай" өрхийн эрүүл мэндийн төв, "Дарив сумын Эрүүл мэндийн төв," Төрийн Аудитын газар, Бигэр сумын Засаг даргын тамгын газар зэрэг 7 байгууллага, 4 иргэнд нийт 14 стандартаар үйлчилсэн. 9 Стандартыг татаж стандартын фондоо баяжуулсан. 12 жилийн 2-р сургуулийн 3-р ангийн 60 хүүхдэд "Хүнсний бүтээгдэхүүнийг мэдрэхүйн аргаар таних нь" сэдвээр сургалтыг зохион байгуулсан.

"Иргэдийн оролцоо- Байгаль орчны хяналт", "Эрүүл аюулгүй орчин- Таны оролцоо " сэдэвт сарын аяны нээлтийг 31 аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон дотоод хяналт хариуцсан 60 гаруй ажилтан, албан хаагчдыг хамруулан зохион байгуулав. Нээлтийн үеэр "Хөдөлмөрийн аюулгүй байдал, осол түүнээс хэрхэн урьдчилан сэргийлэх", "Дотоод хяналт, түүнийг хэрхэн зохион байгуулах" талаар сургалтуудыг хийж, Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын чиглэлээр хийсэн гарын авлага материал тараан зөвлөмж өгч ажиллалаа.

“Иргэдийн оролцоотой–Байгаль орчны хяналт” сарын аяны хүрээнд Чандмань, Эрдэнэ сумуудын иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудадбайгаль орчны багц хуулийг сурталчлах мөн “Оюун ухаанаараа уралдъя” сэдэвт АХА тэмцээнийг 60 гаруй иргэдийг оролцуулан зохион явуулж, тэмцээний үеэр байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр зөвлөмж, гарын авлага тараан өгч ажиллалаа.

“Цэвэр орчин-Эрүүл сум” уриан дор 18 сумын хэмжээгээр зохион байгуулж, аяны хүрээнд 70 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, 720 гаруй иргэд, албан хаагчдыг оролцуулан нийтийн эзэмшлийн газрын цэвэрлэгээ болон малын сэг зэм устгах, зөвшөөрөлгүй цэгт асгасан хог хаягдлыг цэвэрлэж нийт 335 тн хог хаягдлыг төвлөрсөн цэгт тээвэрлэж хүргүүлж, Засгийнгазрын 2018 оны 189 дүгээртогтоолоорбүхтөрлийн 0.035 мм болон түүнээс нимгэн нэг удаагийн нийлэг хальсануутыг худалдаа, үйлчилгээнд сав баглаа боодлын зориулалтаар үйлдвэрлэх, импортлохыг хориглосон шийдвэрийг орон нутагтаа хэрэгжүүлэх зорилгоор “Эко торыг энгийн хэрэглээнд” аяны хүрээнд 50 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, 520 гаруй иргэдэд сурталчилгаа хийсний зэрэгцээ, аймгийн Мэргэжлийн хяналтын газрын бүсгүйчүүдээс даавуун торыг хэрэглээндээ хэвшүүлэх зорилгоор “Цүнхэндээ даавуун тортой” уриалга /Challenge/ -ыг эхлүүлж, уг уриан дор 12 сумын 30 байгууллагын 210 иргэд нэгдсэн.

“Хишиг өдөр”-ийн “Дотоод хяналтыг сайжруулах нь” сэдвээр зохион байгуулж, тус арга хэмжээнд Тэс петролиум ХХК, Монсуль ХХК–уудын дотоод хяналт шалгалт хариуцсан ажилтнуудыг сэлгэн ажиллуулж, холбогдох хяналтын хуудсаар эрсдэлийг тооцож үнэлгээ, дүгнэлт өгч ажилласны зэрэгцээ, Есөнбулаг сумын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 11 ШТС–уудын 20 гаруй ажилтнуудад зөвлөмж, заавар өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар харилцан туршлага солилцож, “Миний нутаг” телевиз, Алтай радиогоор иргэд, олон нийтэд сурталчилж, мэдээлэл хийв.

“Эрүүлаюулгүйорчин- Таныоролцоо” сэдэвт сарын аяны хүрээнд 9 төрлийн зөвлөмж боловсруулан 58 аж ахуйн нэгжид мөн 26 төрлийн тараах материал, гарын авлага бэлтгэн 450 ширхэгийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд тарааж, вэб сайт, цахим хуудсанд 25 төрлийн постер, мэдээ, мэдээлэл бэлтгэн тавьж, 1472 хүний хандалт авсан үр дүн харагдаж байна. Орон нутгийн телевизод 6 удаагийн мэдээлэл, “Алтай радио”-д 1 удаагийн ярилцлага өгч ажиллав.

Тагнуулын ерөнхий газрын харьяа Говь-Алтай аймаг дахь Тагнуулын хэлтсийг урьж “Төрийн болон албаны нууц” –ын тухай хууль дүрэм, мэдээ мэдээлэл сургалт зохион байгууллаа.

МХЕГ-ын 2019.03.28-ны өдрийн 08/1045 дугаар албан бичгийн дагуу МХГ-ын даргын 2019.04.02-ны өдрийн 08/40 дүгээр удирдамжийн хүрээнд аймгийн ОБГ-ын Улсын нөөцийн салбарт 2018 онд нийлүүлэгдсэн өвсний чанар байдалд төлөвлөгөөт бус хамтарсан хяналт шалгалт хийлээ. Хяналт шалгалтаар өвсний нягтрал, жин стандартын шаардлага хангаагүй тул ОБГ-ын дарга болон өвс нийлүүлсэн “Мон шугам энерго” ХХК-ий захирал нарт хохирол барагдуулах тухай улсын байцаагчийн хугацаатай 3 заалт бүхий 2 албан шаардлага хүргүүлэн ажиллалаа.

ЗГ-ын 2018 оны 15 дугаар тэмдэглэлийн дагуу ХХААХҮЯ, МХЕГ-ын хамтран баталсан “Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тухай” удирдамжийг нийслэл орон нутагт хүргэгдсэн тул хяналт шалгалтыг цаг хугацаанд нь явуулж, үйл ажиллагаа явуулаагүй газруудын нотлох баримт, тайлбаруудыг баримтжуулан, ажлын хэсгийн саналыг хяналт шалгалтын танилцуулгад дэлгэрэнгүй тусгаж ХАБХХАГ-т ирүүлэхажлын хүрээнд 4 үйлдвэрт хяналт шалгалт хийхээс 2 газарт шалгалт хийгдсэн.

**Хоёр. Боловсрол, соёл, эрүүл мэнд, хүнсний чанар,  
эрүүл ахуйн бодлогын хүрээнд:**

**Хүүхдийн эрүүл ахуйн хяналтаар:**

Гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Эрдэнэ, Чандмань сумын цэцэрлэ, Чандмань сумын ерөнхий боловсролын сургуульд төлөвлөгөөт шалгалт хийв. Холбогдох хяналтын хуудсаар шалгахад Чандмань сумын сургууль, цэцэрлэг дунд, Эрдэнэ сумын цэцэрлэг бага эрсдэлтэй үнэлэгдэв. Хууль сахин мөрдөлт дунджаар 62% байв.

**Эмчилгээний чанарын хяналтаар:**

Эмчилгээний чанарын хяналт, Эрүүл ахуй, халдвар хамгааллын чанарын хяналт, Эм биобэлдмэлийн чанарын хяналтаар Алтай, Эрдэнэ, Чандмань сумын эрүүл мэндийн төвүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн хатарсан 144 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлэв.

**Эм, биобэлдмэлийн чанарын хяналтын чиглэлээр:**

Эмчилгээний чанарын хяналт, Эрүүл ахуй, халдвар хамгааллын чанарын хяналт, Эм биобэлдмэлийн чанарын хяналтаар Алтай, Эрдэнэ, Чандмань сумын эрүүл мэндийн төвүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн хатарсан 144 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлэв.

Эрдэнэ сумын Өгөөмөр дэлгүүрт БНХАУ-д үйлдвэрлэсэн жирэмснээс хамгаалах эм худалддаг гэсэн иргэний мэдээллийн дагуу хяналт шалгалт хийхэд 1ул жирэмснээс хамгаалах эм илэрсэнийг хураан авч ЗТХ-ийн 6.6 дугаар зүйлийн 11 дэх хэсэгт заасны дагуу иргэн Д.Насанхүүд торгох арга хэмжээ авч ажиллав.

**Орчны эрүүл ахуй, халдвар судлалын хяналтаар:**

Эмчилгээний чанарын хяналт, Эрүүл ахуй, халдвар хамгааллын чанарын хяналт, Эм биобэлдмэлийн чанарын хяналтаар Алтай, Эрдэнэ, Чандмань сумын

эрүүл мэндийн төвүүдэд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, улсын байцаагчийн хатарсан 144 заалт бүхий 3 албан шаардлага хүргүүлэв.

### **Хүнсний чанар, стандарт, эрүүл ахуйн хяналтаар**

Улаанбаатар хотоос чанарын шаардлага хангахгүй, хадгалалт, тээвэрлэлтийн горим алдагдсан хугацаа дууссан хүнсний бүтээгдэхүүн орон нутаг очих эрсдэлээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг чангатгах ажил болон Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Прокурорын газар, Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Татварын хэлтэстэй хамтран Шинэ-Алтай ХХК-ын худалдаа үйлчилгээний төвд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч 23 хүнсний худалдаа, 8 цайны газрыг хамруулан шалгаж “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай”, “Зөрчлийн тухай” хуулиуд болон тэдгээртний цүүлэн гаргасанд дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулан, дотоод хяналт шалгалтыг хэрхэн зохион байгуулах, илэрсэн зөрчил дутагдлыг гарилгах, гарч болох эрсдэлээс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар мэргэжил гаргаж зүйн зөвлөгөө өгч, 3 төрлийн гарын авлага материалыг 68 иргэнд тараан ажиллав.

Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу 5 талх, нарийн боовны цех, 1 мах, махан бүтээгдэхүүний цех, 1 хоол үйлдвэрлэлийн газар, сургууль цэцэрлэгийн 4 хоол үйлдвэрлэлийн газарт хамтарсан хяналт шалгалт, 7 хүнсний дэлгүүрт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэн в. Архи согтууруулах ундаа худалдан борлуулдаг 3 дэлгүүрт хүсэлтийн дагуу тодорхойлолт гаргаж хүргүүлэв. Улсын байцаагчдын хамтарсан 7 албан шаардлага, 7 зөвлөмж хүргүүлэн ажиллав.

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч бөгөөд төрийн захиргааны удирдлагын газрын дарга нарын хамтарсан 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн 01/120 дугаар “Согтууруулах ундааны үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагаа, тусгай зөвшөөрлийн хугацаа, нөхцөл, шаардлагын хэрэгжилтэд хяналт шалгалт хийх тухай удирдамжийн дагуу Говь-Алтай аймагт үйл ажиллагаа явуулдаг Есөнбулаг сумын архи үйлдвэрлэлийн “Алтайн дэлгэрэх” ХХК, “Ентүм” ХХК,

Бигэр сумын архи, дарс үйлдвэрлэлийн “Шимт дээж” ХХК-уудын үйлдвэрлэлийн тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах, цуцлах асуудлыг шийдвэрлэн ажиллав.

### **Гурав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:**

#### **Мал үржил, Мал эмнэлэг, Ургамал хамгаалал, хорио цээр:**

Эрдэнэ сумын 2 нэгж, Чандмана сумын 2 нэгж, Халиун сумын 3 нэгж бүгд 7 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, Халиун сумын 1 мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, 3 нэгжийн хяналт шалгалтын дүн мэдээг шилэн хяналтын системд оруулав.

#### **Мал үржлийн хяналтын чиглэлээр:**

Алтай сумын иргэн М.Өнөржаргалын шувууны аж ахуй, Бигэр сумын иргэн С.Мөнхтөр, Т.Батболд нарын өрхийн гахайн аж ахуйд төлөвлөгөөт хяналт шалгалт хийж, хяналтын хуудсаар 1 объект дунд, 2 объект бага эрсдэлтэй үнэлэгдэн илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар улсын байцаагчийн 1 албан шаардлага өгч, байгууллагын сургалт зохион байгуулан ажиллав.

Чандмана сумын “Гичгэний хяр” ХХК-ий Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгжид төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхэд дунд эрсдэлтэй үнэлэгдэж, хамтарсан зөвлөмж хүргүүлэв.

### **Дөрөв. Байгаль орчин, уул уурхай, хөдөлмөр, хөдөлмөрийн эрүүл ахуй, нийгмийн хамгаалал, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:**

#### **Хяналт шалгалтын ажил:**

5 сумд төлөвлөгөөт 6, урьдчилан сэргийлэх 5, зөвлөн туслах үйлчилгээ 6 нийт 25 аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, 87 зөрчил илрүүлэн 28 зөрчлийг газар дээр нь арилгуулан улсын байцаагчдын 61 заалт 8 албан шаардлага, 7 дүгнэлт, 58 заалт бүхий 11 зөвлөмж хүргүүлэн ажиллав.

#### **Авто замын хяналтаар:**

Алтай хотын төвийн үерийн далангийн хог, сэг зэмийг цэвэрлэх, ус зайлуулах байгууламжийн бэлэн байдлыг хангуулж ажиллах талаар холбогдох газруудад албан тоотоор үүрэг чиглэл өгч ажилласны үр дүнд орон нутгийн чанартай авто замд байрлах 42ш ус зайлуулах байгууламж, 8 км үерийн далангийн хог сэг зэмийг цэвэрлүүлэх арга хэмжээ авч ажилласан бөгөөд энэ ажилд нийт 60 аж ахуйн нэгж, 1600 гаруй айл өрх, 12 тээврийн хэрэгсэл, 4 механизм 4 өдөр ажилласан байна.

Алтай хотыг дайран өнгөрч байгаа улсын чанартай авто замд байрлах 4 чиглэлийн 776 км авто замд байрлах 60 гаруй ус зайлуулах байгууламж, гүүр хоолойд үзлэг шалгалтыг гүйцэтгэж, засвар арчлалтын ажлыг бүрэн хийж, ус зайлах нөхцөл бүрдүүлж ажилласны гадна иргэд, тээвэрчдийг баталгаатай авто замаар зорчих, гарцгүй газраар гол гатлахгүй байх, шар усны үерээс болгоомжлох талаар 8 заалт бүхий 2 сэрэмжлүүлэг гаргаж, олон нийтийн сүлжээнд байршуулж ажиллав.

Шар усны үертэй холбогдуулан иргэдийг баталгаатай авто замаар зорчих талаар сэрэмжлүүлэх хуудас 2-ыг гарган, олон нийтийн сүлжээнд тавин ажиллан, авто замын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа 4 аж ахуйн нэгжид хариуцуулан өгч, үзлэг шалгалтыг байнга хийж, илэрсэн зөрчлийг арилгаж, авто замыг бэлэн байдалд байлгаж, зорчигч тээвэрчдийг бодит мэдээллээр хангаж ажиллах талаар албан тоотоор үүрэг чиглэл өгч, биелэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

Барилгын техникийн хяналтын чиглэлээр:

Улсын төсвийн хөрөнгөөр Цогт сумд “Сод Инк” ХХК-ийн барьж байгаа 10 ортой эмнэлгийн барилгад 2019 оны 01/87 тоот удирдамжийн хүрээнд урьдчилан сэргийлэх хяналт хийж холбогдох албан тушаалтанд улсын байцаагчийн 19 заалт бүхий зөвлөмжийг хүргүүлэн ажиллав.

Алтай, Цогт, Бигэр, Баян-Уул сумын 7 аж ахуй нэгжийн барилгын чанар аюулгүй байдалд үзлэг шалгалт хийж ажилласны үр дүнд 2 барилгыг буулгаж, шинээр барихаар шийдвэр гаргуулан ажиллаж байна.

Эрчим хүчний чиглэлээр:

МХЕГ-ын даргын баталсан 2019 оны 01/81 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Алтай хотод байрлах “Дашваанжил” ХХК-ийн үйл ажиллагаа болон хэрэглэгчдийн хийн баллоны техникийн магадлалын баталгаажилт, автомашиныг хийгээр цэнэглэх станцын үйл ажиллагаанд хяналт шалгалтхийж ажиллаж байна.

МХЕГ-ын даргын баталсан 2019 оны 01/143 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу Есөнбулаг сумын ЗДТГ, Захирагчийн ажлын алба, хангагч байгууллага болох “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨК, “Мандал голомт” ХХК, “Ундарга Алтай” АТҮГ зэрэг аж ахуйн нэгж, айл өрхийн 747 инженерийн шугам сүлжээний хяналтын худагт урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийж, 8 худгийг тагжуулан стандартын шаардлагад нийцүүлэн ажиллав.

МХЕГ-ын даргын баталсан 2019 оны 01/48 дугаартай урьдчилан сэргийлэх удирдамжийн дагуу “Алтай-Улиастай Эрчим Хүчний Систем” ТӨХК-ийн болон Алтай хотын нийтийн эзэмшлийн гудамж талбайн ил задгай шугам, кабельд үзлэг шалгалт хийж ажиллахад Жаргалант багт байрлах өргөө хорооллын 2-р байрны цахилгаан дамжуулах кабель шугамын тэжээлийг тасдуулан, засвар үйлчилгээ хийлгэж ажиллалаа.

Эрдэнэ, Чандмань сумдын “Алтай-Улиастай ЭХС” ТӨХК-ийн салбар, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд, гудамж талбайн цахилгааны аюулгүй байдалд үзлэг шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлуудыг газар дээр нь арилгуулан, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

Хэмжил зүйн хяналтаар:

2 сумын 5 ШТС-ын шахалтын байдалд шатахуун түгээгүүрийн хошуу бүрээс 2 удаагийн давталтаар 10л мерник ашиглан шалгахад хэвийн шалгагдав.

“Шинэ-Алтай” ХХК-ийн худалдааны төвд үйл ажиллагаа явуулж байгаа 42 иргэн, аж ахуйн нэгжийн хэмжүүр, хэмжих хэрэгсэлд шалгалт хийхэд 30 зөрчил

илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 2 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлэв.

12 аж ахуй нэгжийн гүний усны худгийн хэмжих хэрэгсэлд урьдчилан сэргийлэх шалгалт хийж, зөвлөмж хүргүүлэн ажиллав.

Авто тээврийн хяналтаар: Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу өргөх байгууламж ашигладаг 1 аж ахуйн нэгжид Зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 3 заалт бүхий зөвлөмж хүргүүлэв.

Нийгмийн хамгааллын хяналтаар: 3 аж ахуйн нэгж байгууллагад төлөвлөгөөт зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, 25 зөрчил илрүүлэн, 5 зөрчлийг газар дээр нь арилгуулан, 20 заалт бүхий 3 зөвлөмж хүргүүлэв.

Байгаль орчны хяналтаар: төлөвлөгөөт 11, төлөвлөгөөт бус шалгалт 3 хийж, зөвлөн туслах 4 хийж, шалгалтаар илэрсэн дутагдал 6 албан шаардлага, зөвлөмж 4 өгч, 7.0 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ авав.

Геологи уул уурхайн хяналтын чиглэлээр: МХЕГ-ын даргын баталсан 2019 оны 01/26 тоот удирдамжийн дагуу төлөвлөгөөт бум хяналт шалгалтыг 3 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулах зорилгоор 15 заалт бүхий 3 албан шаардлага өгч, 2 аж ахуйн нэгж, 2 иргэнд 12.3сая төгрөгний шийтгэлийн арга хэмжээ авч барагдуулан ажиллав.

Газар, геодезизурагзүйнхяналтаар: 5 аж ахуйн нэгж, 4 иргэнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж, зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор нийт 74 заалт бүхий улсын байцаагчдын хамтарсан 9 албан шаардлага хүргүүлж ажиллав. 1 иргэнд Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 500.0мянган төгрөгний шийтгэврийн арга хэмжээ тооцож ажиллав.

1 аж ахуй нэгжид зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж 5 заалттай хугацаатай зөвлөмж хүргүүлсэн.

#### **Тав. Нэгдсэн лаборатори:**

Лабораторид 3 байгууллага, 33 аж ахуйн нэгж, 4 иргэнээс ирүүлсэн хүнсний бүтээгдэхүүний 75 сорьцод 252 үзүүлэлтээр, унд, ахуйн усны 24 сорьцод 210 үзүүлэлтээр, бохир усны 5 сорьцод 18 үзүүлэлтээр, хөрсний 3 сорьцод 15 үзүүлэлтээр, үрийн материалын 1 сорьцод 6 үзүүлэлтээр, гадаад орчны арчдасны 159 сорьцод 318 үзүүлэлтээр хими, нян судлал, үрийн чанар, хорио цээрийн шинжилгээ хийхэд унд, ахуйн усны 6 сорьц 6 үзүүлэлтээр /стандартаас магнийн хатуулаг 18 мг/л-ээр их, нянгийн тоо 58-аар их/, стандартаас төмөр 3 мг/л-ээр их, Е.Коли, салмонелла илэрсэн/, /стандартаас магнийн хатуулаг 68 мг/л-ээр их, кальцийн хатуулаг 10 мг/л-ээр, нийт хатуулаг 4-6.6 мг\*эқв/л-ээр, нянгийн тоо 7-150-аар их/ “Шимтсуль” сульхартай цайны 1 сорьцод 1 үзүүлэлтээр /чийглэг стандартаас 2- оор бага/ ундны усны 1 сорьцод 1 үзүүлэлтээр нянгийн тоо стандартаас 14- өөр их/ стандартын шаардлага хангаагүй.

Бургастайн боомтын орох чиглэлд Монгол Улсын хилээр нийт 1601 тээврийн хэрэгсэл орж ирснээс гадаад 1594 тээврийн хэрэгсэл, Монгол Улсын 7 тээврийн хэрэгсэл тус

тус орж ирсэн байна. Тус Улсад орж ирсэн зорчигчдын тухайд нийт 1607 зорчигч орж ирснээс Монгол Улсын иргэн 13, гадаадын иргэн 1525 орж ирсэн.

Гарах чиглэлд: Монгол Улсын хилээр нийт 1594 тээврийн хэрэгсэл гарснаас тус улсын 6 тээврийн хэрэгсэл гарсан байна. Зорчигчдын тухайд нийт 1538 иргэн гарсанаас гадаадын иргэн 1596, Монгол Улсын 11 иргэн тус тус зорчсон байна.

Тус боомтоор тайлант сард 155509 тн төмрийн хүдрийн баяжмал экспортлогдсон байна.

### СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЛААР

Алтай сум “Сум хөгжүүлэх сангийн зээл”-ийн хэтрэлттэй хүмүүсийн мэдээллийг сонсож, хяналтын зөвлөлийг шинэчлэн байгууллаа.

Баян-Уул сумын багш, ажилтны ажил төрлийн цуглааныг зохион байгууллаа. Цуглаанаар “Сахилга хариуцлага, ёс зүйтэй, бүтээлч сарын аян” өрнүүлэх, төгсөлтийн арга хэмжээг зохион байгуулах, ЭЕШ-ын бэлтгэлийг эрчимжүүлэх, багш нарт мэргэжлийн зэрэг олгох, гадуур эргүүл жижүүр гаргах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Бигэр сумын орон нутаг судлах танхимын барилга барих гүйцэтгэгч компани 4 дүгээр сарын 17-ны өдрөөс ажлаа эхлүүлж барилгын ажил 40 орчим хувьтай явагдаж байна.

Бугат сум “Иргэдийн оролцоотой байгаль орчин хяналт” сарын аяны төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Жаргалан сумд малын гоц халдварт боом өвчний шинж тэмдэг илэрч аймгийн Мал эмнэлгийн лабораторийн шинжилгээгээр баталгаажсан тул сумын Онцгой комисс хуралдаж мэргэжлийн ангийн бие бүрэлдэхүүнд бэлэн байдал зарлан Завхан гол багийн нутаг “Олон нүхт”-д үхсэн 3 үхрийн хүүрийг булаг шанд, намаг бүхий газраас гаргаж төвлөрсөн хогийн цэгт авч ирж устгууллаа.

Тонхил сумын хэмжээнд өглөө бүр “Хөдөлгөөн-Эрүүл мэнд” гүйлтийг зохион байгуулж, сумын ард иргэд, байгууллага хамт олны төлөөлөл 45 хүнийг хамруулан хөдөлгөөнт дасгал, гар бөмбөгийн анхан шатны мэдэгдэхүүнийг олгож байна.

Төгрөг сумын 12 жилийн сургуульд 7 хоног бүрийн 4 дэх өдрийн 16:30 цагаас “Хамтдаа хөгжье” арга хэмжээг явуулж байгаа бөгөөд энэ сард Багшийн хөгжлийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулиар сургалт зохион байгуулж явуулж, алтан хонх, АХА тэмцээнийг явууллаа.

Цогт сум мал аж ахуйн 7 багийн тойргийн хурлыг 2018.04.23-2018.04.29-ны өдрүүдэд зохион байгууллаа.

Цээл сум 4 багийн малчин өрхүүдэд Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, ЗГ-ын 225 дугаар тогтоолыг сурталчилан таниулж 180 өрхийн 220 гаруй иргэдийг хамрууллаа.



Чандмань сумын Засаг даргын Тамгын газар иргэд хөдөлмөрчдийн санал хүсэлтийг хүлээн авах хайрцгийг байгууллага бүр ажиллуулж, гарсан санал хүсэлтийн мөрөөр шуурхай ажил зохион байгуулж ажиллаж хэвшлээ.

Шарга сумын Баянгол, Хамтын хүч багийн Иргэдийн Нийтийн хурлыг зохион байгуулж, цаг үеийн болон шинэчлэгдсэн хууль тогтоомжийн талаар мэдээллийг танилцуулан малчдаас Манжуур хотод аялах эрхийн бичгийг гардууллаа.

Есөнбулаг сумын Хүн амын урьдчилан сэргийлэх үзлэгийг Жаргалант-Алтай 13.5%, Марал-Алтай 10,6%, Энх-Алтай 12.1%-тай хүргээд байна. Артерийн эрт илрүүлэлт Жаргалан-Алтай 31.8%, Марал-Алтай 10.6%, Энх-Алтай 12.1%-тай, Чихрийн шижингийн эрт илрүүлэлт Жаргалан-Алтай 31.1%, Марал-Алтай 6.8%, Энх-Алтай 9.1%-тай, Элэгний В, С вирусийн эрт илрүүлэлт Жаргалан-Алтай 22.2%, Марал-Алтай 0%, Энх-Алтай 3.5 хувьтай байна.